

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 66

1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7 – 52
2.	<i>Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудиторт хандсан асуултын хариуг хэлэлцэх</i>	52 – 66

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 14-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Г.Ганбаатар, П.Ганзориг, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Ч.Номин;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа.

Дэд хорооны даргыг сонгох тухай асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Х.Ганхуяг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшсэн Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар нь томилолттой тул уг асуудлыг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Х.Ганхуяг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав. /10.20/

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ариунбилэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын бодлогын газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”

төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал М.Амгаланбаатар, Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газрын дарга Б.Батсайхан, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Батырбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын ахлах шинжээч А.Мөнхсайхан, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын ахлах шинжээч Э.Ган-Эрдэнэ, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Төсөл хөгжүүлэлтийн газрын төслийн менежер Ц.Цэнгэл оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин, П.Сайнзориг, Д.Батбаяр, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Түвшин нар үг хэлэв.

Х.Ганхуяг: 1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төр, хувийн шинэ түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 5

Бүгд: 19

73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 6

Бүгд: 19

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор хандсан асуултын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудиторов газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын асуултын хариуг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Монгол Улсын Ерөнхий аудиторт Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн асуудлаар тавьсан асуултын хариуг хэлэлцэж дуусав.

Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 18 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 16 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Т.Аубакир, Жигжидийн Батжаргал, Баатаржавын Мөнхсоёл, Ганзоригийн Тэмүүлэн, Далайн Батбаяр, Жамбын Батсуурь, Батжаргалын Заяабал, Даваахүүгийн Пүрэвдаваа, Дашцэрэнгийн Энхтүвшин, Ринчиндоржийн Батболд, Жамбалын Ганбаатар, Загджавын Мэндсайхан, Пүрэвжавын Сайнзориг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гээд нийт гишүүдийн 51 хувь ирсэн тул хуралдаанаа эхлүүлье. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэгд, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудал үргэлжилнэ.

Хоёрт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Гуравт, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Монгол Улсын ерөнхий аудиторт эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар тавьсан асуулгын хариуг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүн байна уу?

Нэгдүгээр асуудал дээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр Ардчилсан намын бүлгээс Даваагийн Цогтбаатарыг санал болгосон байгаа.

Д.Цогтбаатар нь гадаад улсад томилолттой яваа тул энэ нэгдүгээр асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэх горимын санал гаргаж байна.

Гишүүд санал хураалтад бэлдээдэх үү? Санал хураалт. Б.Заяабал гишүүн орж амжаагүй болохоор санал хураалтыг дахиад явуулъя тэгэх үү? Б.Түвшин санал хураалтад орчих.

Саяын санал хураалт саяын санал хураалтыг хүчингүйд тооцох тухай санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Зарлагын хяналтын дэд хорооны даргаар Даваагийн Цогтбаатарыг сонгох асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэхээр Та бүхнээс санал хураахаар бэлдье. Санал хурааа. /алх цохив/

17 гишүүнээс 13 гишүүн дэмжсэн байна.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 2 хууль, Улсын Их Хурлын 2 тогтоолын төсөл буюу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Монгол Улсын төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Дашнямын Ариунбилэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хууль эрх зүйн

хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Монхоогийн Амгаланбаатар “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал, Баатарсүрэнгийн Батсайхан Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, З.Батырбек Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Адъяагийн Мөнхсайхан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын ахлах шинжээч, Эрдэнэбилэгийн Ган-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын ахлах шинжээч, Цолмонгийн Цэнгэл “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Төсөл хөгжүүлэлтийн газрын төслийн менежер гээд.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Микрофон өгөөрэй.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 2 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төсөл болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдэд дараах агуулгатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд:

Айл өрх, иргэдийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нь хамгаалах, орлогын тэгш бус байдлыг бууруулах, бизнесийн идэвхжилийг дэмжих, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар нийт иргэдийн 75 хүртэл хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвараас 50-аас 100 хувь хөнгөлөгдөх юм. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн процесс ажиллагааг багасгах, түншлэлийн хүрээг тэлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх орон нутгийн түвшинд түншлэлийн төслийг бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт очих ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх зорилгоор 2026 оны төсвийн жилд арилжаалах гадаад болон үнэт цаасны дээд хэмжээ зориулалтыг тусгасан Засгийн газрын үнэт цаас гаргах, эрх олгох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулан хурд ашиглалтыг сайжруулах зорилгоор “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулж өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: 2026 онд Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асуух гишүүн байна уу?

Д.Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Ж.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Төр, хувийн хэвшлийн түншлэл гэдгээс нь асууя.

Би Эдийн засгийн сайдаас чуулган дээр асуусан юм. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр. Тэгээд Сангийн яамнаас хүн байгаагүй учраас би Ж.Ганбат даргаас асууя.

Ж.Ганбат дарга ирэх онд алтыг 20 тонн гэж төлөвлөсөн байна. Тэгээд ямар үнээр төлөвлөсөн юм бол? Тэгээд энэ жилийн чинь гүйцэтгэлийг би одоо Монголбанкны сайт руу ороод харахаар 7.7 тонн гэсэн байна лээ. Тэгээд сүүлийн жилүүдэд ерөөсөө 20 тоннд хүрэхгүй байгаа л даа. Тэгээд хэрвээ үүнийг ингээд 10 тонноор яривал бараг 1.3 тэрбум долларын дутуу орлого орно шүү дээ. Илүү төлөвлөсөн гэсэн үг.

Бид төр, хувийн хэвшлийн түншлэлээс асууж байгаа шүү. Дандаа төр алт гаргадаггүй юм.

Нүүрс ялгаа байхгүй 90 сая тонн гэсэн. Тэгээд энэ жилийн чинь гүйцэтгэл хэд юм? 90 сая тонн чинь хүрэх юм уу? 90 сая тонноо хэдээр төлөвлөсөн юм? Хэдэн доллароор. Тэгээд ахиад төсвийн тодотгол яах билээ? Бий дээ.

Би нэг их зарлага талд нь юм ярьдаггүй шүү. Тэрийг ингэсэн байна, үүнийг ингэсэн байна, манай тойрог ингэсэн байна, тэгсэн байна гэж юм ярьдаггүй шүү.

Одоо орлого талаа зөв төлөвлөөд тодотгол гэхгүйхэн шиг нэг аятайхан явах, зөв явах шаардлагатай гэдэг үүднээс байнга асуудаг юм.

Зэс 2025 онд 2 сая тонн зэсийн баяжмал экспортолно гэсэн.

Тэгээд 2026 онд 1.9 гэх юм. Сүүлийн жилүүдэд байнга өссөн. Тэгээд яагаад 100 мянган тонноор бууруулсан юм бол? Энэ жилийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл надад байхгүй байна.

- Зэсийн баяжмал ямар үнээр тооцож байгаа юм?
- Алт ямар үнээр тооцож байгаа юм?
- Нүүрс ямар үнээр тооцож байгаа юм?

Уг нь төсөв чинь хуваарийнхаа дагуу ороод ирвэл асууя гэсэн. Тэгээд төсөв чуулганаараа хэлэлцэгдэхгүй байна л даа. Тэгээд яах вэ би дагах хуулийн дээр нь тэр төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг дээрээс нь асууж байна. Хариултын дараа тодотгоё. Баярлалаа.

Х.Ганхуяг: Ж.Ганбат даргын микрофоныг өгье. 2 номер.

Ж.Ганбат: Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 64.4 сая тонн нүүрс гарсан байгаа. Энэ өнгөрсөн оны яг мөн үетэй харьцуулахад биет хэмжээний хувьд өнгөрсөн оны мөн түвшин дээрээ нүүрс байгаа.

Бид энэ тоон дээрээ үндэслэж ирэх жил нүүрсний биет хэмжээг 90 сая тонн гэж тооцож оруулсан байгаа. Тэгэхээр бид үүнийг биет хэмжээний хувьд биелэх бүрэн бололцоотой гэж тооцож байгаа.

Үнийн хэлбэлзэл энэ оны хувьд нүүрсний үнэ 40 хувиар буурсантай холбогдуулан үнэ дээр бид орлого жоохон хүндэрч байгаа юмнууд байгаа. Одоо эхний 9 сарын байдлаар төсвийн орлого нь 800 гаруй тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан байгаа.

Тэгэхээр нүүрсний хувьд биелэх бүрэн бололцоотой юм үзсэн байгаа. Зэсийн үнийг бид зах зээлийн үнийг нь 9700 ам.доллараар тооцсон байгаа.

Зэс дээр Оюу Толгойгоос болон Эрдэнэт үйлдвэрээс ирүүлж байгаа биет хэмжээг үндэслэж бид төсөв дээр төлөвлөж байгаа. Ийм учраас бид энэ дээр зэсийн хувьд бага зэргийн бууралттай биет хэмжээ нь байгаа. Яах вэ бид макро эдийн засгийн тоонууд болон экспортын биет хэмжээний тоонуудыг Эдийн засгийн яамнаас өгсөн тоон дээр үндэслэж тооцсон байгаа.

Бусад уул уурхайн бүтээгдэхүүний хувьд бүрэн биелээд явах бололцоотой юм гэдэг байдлаар бид төсөв дээрээ төлөвлөж тооцсон байгаа.

Х.Ганхуяг: Ж.Ганбаатар гишүүний микрофон өгье.

Ж.Ганбаатар: Асуултаа сайн сонсоорой доо.

Тэгээд нүүрс хэдээр тооцсон юм гэхээр хариулахгүй юм. Наад алтны чинь биет хэмжээ өнөөдрийн чинь гүйцэтгэл.

Тэр Монголбанкны сайт руу ороод хараарай. 7.7 тонн гэсэн байгаа. Тэгээд сүүлийн жил. Наад 20 тонн гэвэл. Алт хэрвээ чи 4 мянгаар тооцсон наад төсвийн орлогын чинь зөрүү маш их мөнгө гарна шүү. Багаар тооцсон байж магадгүй. Хуучин шиг алт чинь 1500 биш. Маш үнэтэй болсон байна шүү дээ.

Тийм учраас тэр 20 тонн гээд үеийн үед нэг бэлгэдлийн чанартай тавьдаг. Наадахаар чинь сох дутна шүү. Наадах чинь маш их хэмжээний мөнгө шүү. Хэрвээ 20 тонныг өнөөдрийн үнэ цэнд үржүүлбэл наадах чинь бараг 2.6 тэрбум доллар болж байна лээ. 2.6 тэрбум доллар. 1 тонн алт 130.0 сая доллар гэж тооцвол.

Х.Ганхуяг: 2 номер.

Ж.Ганбат: Хариулъя.

2024 оны гүйцэтгэлээр алт 11.6 тонн гарч.

2025 оны төсөв дээр эхний анх батлагдсан төсөв дээр бид 18 тонныг тооцсон. 2025 оны сая 7 сард хийсэн тодотгол дээр бид 16.5 тонн гэж бууруулж тооцсон байгаа.

Үнийн хувьд алт 2900 ам.доллараар унацыг нь тооцсон алт түүхэн дээд хэмжээндээ үнэ 4 мянгад яг одоогийн байдлаар хүрсэн. Алтны үнэ нэлээн өндөр өсөлттэй байгаа.

Бид биет хэмжээг алтан дээр тодорхой арга хэмжээг Монголбанк Засгийн газраас авч хэрэгжүүлээд ирэх оны алтыг 20 тонн алт гаргана гэдэг байдлаар тооцсон. Үнийг бид алтан дээр 2026 онд 2800 ам.доллараар тооцсон. Одоо 4 мянга хүрээд байгаа.

Тэгэхээр яах вэ, бид... /минут дуусав/

Х.Ганхуяг: 2 номер нэмээд хариул.

Ж.Ганбат: Алт дээр үнэ өндөр өсөлттэй байгаа учраас алтны олборлолт, борлуулалт дээр нэмэгдэх бололцоотой байгаа гэдэг байдлаар алтыг тооцож тусгасан байгаа.

Зэсийн хувьд ирэх жил бид зэс дээр тэнцвэржүүлсэн үнийг бид зах зээлийн үнийг 9700-гаар тооцсон. Тэнцвэржүүлсэн үнийг 8341.8 ам.доллар 2026 онд гэж тооцсон байгаа. Зэс дунд ер нь харьцангуй тогтвортой байгаа. 2024 оны гүйцэтгэлээр зэсийн зах зээлийн үнэ 9184-тэй байсан. Энэ оны төсвийн тодотгол дээр 9200-гаар авсан. Зэсийн үнэ дээр бид харьцангуй эрсдэл багатай, тогтвортой байгаа.

Х.Ганхуяг: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би орлого талд чинь санаа зовоод хэлж байгаа шүү.

Наад алт чинь өнөөдрийн гүйцэтгэл нь 7.7 тонн. Та нарт өөр мэдээ байж магадгүй. Чи зүгээр сайт руу нь ороод хараарай. Монголбанк. Та нарт өөр мэдээ өгсөн юм уу. Мэдэхгүй. Тэрийгээ тэгээд мэдээлдэг юм уу, үгүй юу.

Зүгээр 9 тоннд хүрсэн юм шиг юм ярина лээ. Тэгсэн ч гэсэн наадах чинь хоёрхон сарын дотор ахиад 10 тонн алт тушаана гэж байхгүй шүү дээ. 16 гэж тооцсон бол.

Тэгэхээр наадах чинь аягүй их зөрүү гарна шүү. Маш их зөрүү гарна.

Хоёрдугаарт, наад зэс чинь Оюу Толгой чинь дангаараа 2 сая тонн гаргана гэж одоо миний үед л ярьдаг байсан юм даа. 2026 онд. Тэгээд Эрдэнэтийн 560-ыг нэмэхээр 2 сая 560 мянган тонн болмоор юм. Тэгээд Та болохоор бууруулсан байх юм. Эсвэл наад юу чинь бараг ухаад дууссан юм уу? Оюу Толгой чинь.

Х.Ганхуяг: Эдийн засгийн яамнаас хэн байна? И.Батхүү байна уу? Эдийн засгийн яамнаас хэн байгаа юм бэ? 7 номер.

Т.Баясгалан: И.Батхүү дарга ENTRÉE-ийг ажлын хэсгийн хуралтай байгаа учраас өнөөдрийн хуралд оролцож чадахгүй болсонд хүлцэл өчье.

Яг саяын асуултад Н.Учрал сайд одоо орж ирж байгаа. Нэмэлтээр хариулт өгөх байх аа.

Х.Ганхуяг: И.Батхүүг дуудаарай. Ж.Батжаргал гишүүний микрофон өгье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсөв дагасан хууль тогтоолуудаас хоёр зүйл асуух зүйл байгаад байгаа юм.

Нэгдүгээрт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа юм билээ. Бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн зориулалттай дэд бүтэц төрийн үйлчилгээний чиглэл рүүгээ түншлэл аваад яваад байсан. Өргөтгөж байгаа юм нь болохоор хөгжлийн бодлого, зорилтуудад орсон томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд бас түншлэлийг ашиглаж болох юм гэсэн ийм санаа энэ дотор ороод байгаа юм уу гэж танилцуулга дотроос нь харагдаад байгаа юм. Энэ ямар ямар чиглэлүүд дээр ийм өргөтгөж түншлэл ашиглах бололцоо байна вэ гэдэг асуудал.

Хоёр дахь зүйл нь, орон нутгуудад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх асуудлуудыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд судалж үзээд санхүүжилтийн эх үүсвэр талаас нь хамааруулаад зарим дээр нь зөвшөөрөл олгох, зарим дээр нь дүгнэлт гаргах ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр уг түншлэлийн өөрийнх нь зардал ер нь ямар хэмжээтэй байх. Түүнийг орон нутгууд ямар хугацаанд дааж чадах, тэгээд өгөөж талынх нь асуудал ямар байх энэ тэр гээд зүйлүүдийг хооронд нь уялдуулж харсан тийм зохицуулалт энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дотор чинь бий билүү? Одоо зөвхөн нэг заалтаар зөвшөөрөл өгөх, дүгнэлт өгөх тухай л асуудал ороод яваад байгаа шүү дээ.

Тэгэхээр 10, 20 жилээр тодорхой асуудлууд дээр дүгнэлт өгөгдөөд явдаг. Зөвшөөрөл өгөгдөөд явдаг. Үүнээс болоод дараа дараагийн хөгжлийн үр өгөөжийн асуудлууд дээр ямархуу үр дүн гарах вэ гэдэг асуудал гарч ирэх гээд байна уу даа гэмээр юм харагдаад байгаа юм.

Тэгэхээр энэ талын зохицуулалтыг ер нь юу гэж харсан бэ гэдэг нэг ийм зүйл байна. Үнэхээрийн бидэнд төсвийн орлогын бүрдэл талын асуудал дээр ч тэр, зардал талын асуудал дээр тухайлсан, тусгайлсан зохицуулалтуудтай учраас бас төр, хувийн хэвшлийн түншлэлээр шууд хөрөнгө оруулалтыг татах хэлбэрээр дэмжих хэлбэрээр хийх ёстой асуудлууд байгаад байгаа. Үнэн. Тэгээд үүнийгээ зөв зохицуулах тал дээр ер нь ямархуу бодлого чиглэл байна вэ гэдэг нэг ийм зүйл.

Хоёр дахь зүйл нь, тэр Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай асуудал байгаад байгаа юм. Энэ дээр би хувийн хэвшлийг татаж оруулж ирэхээр асуудал байгаа юм байна гэж тогтоолын үзэл санаа талаас хараад байгаа.

Тэгэхээр энд ер нь ямархуу бодлого, чиглэл баримтлагдаж байна вэ гэдэг асуудал. Нэгэнт стратегийн орд учраас Баялгийн сангийн хуультайгаа уялдаж... /минут дуусав/

Х.Ганхуяг: Дараа нь тодруулъя. Хэн хариулах юм? 7 номер хариулж мэдэх юм уу? 7 номер.

Т.Баясгалан: Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд түншлэлийн төсөлд тавигдах шаардлагыг хуульчилсан байдаг.

Энэ зүйлийн 18.1.2-т хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх шаардлагыг түншлэлийн төсөлд хамгийн түрүүнд нийтлэг шаардлагаар тавьж байгаа.

Тийм учраас 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төслүүд, мөн Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих санхүүгийн эх үүсвэргүй болсон төслүүдийг урьдчилсан үнэлгээ бүрэн шинжилгээ хийх замаар үнэхээрийн түншлэлээр хэрэгжүүлэхэд оновчтой тохиромжтой гэж үзэх юм бол түншлэлийн хуулийн дагуу дээрх төслүүдийг түншлэлээр хэрэгжүүлээд явах боломжтой юм гэдэг агуулгаар бид энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг санаачилж өргөн барьсан байгаа юм.

Аймагтай холбоотой асуудал дээр өнөөдөр яг түншлэлийн төслөөр хуулийн 13.1, 13.2-т зааснаар нийслэл болон 12 аймагт түншлэлийн төсөл хэрэгжүүлэх эрх нь байгаад байгаа.

Тэгээд хуулийн шаардлагаар 100 мянгаас дээш хүн амтай салбар, эсвэл улсын төсвөөс дараалан 3 жил татаас аваагүй гэдэг шаардлага тавигдсаныг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр болиулаад 21 аймаг нийслэлтэй адилхан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан 6 салбараар богино болон 100 тэрбум төгрөгөөс доош төслүүдийг аймаг, нийслэл хэрэгжүүлэх бүрэн боломжтой байхаар эрх зүйн зохицуулалтыг нь нээж өгч байгаа.

Тийм учраас төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүд дээр салбарын яамд нь саналаа гаргаад манай яаманд ирүүлдэг. Бид хамгийн нэгдүгээрт нь хардаг зүйл нь сая Ж.Батжаргал гишүүний асуугаад байгаа хөгжлийн урт, дунд, богино хугацааны болон бодлогын баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нь тусгагдсан, хэрэгжүүлэхээр орсон эсэхийг нь хянадаг.

Гэхдээ энэ бүх хөгжлийн бодлогын баримт бичигт туссан төслүүдийг бас бүгдийг нь түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бүрэн шинжилгээ хийж дүгнэлт гарсны дараа яг түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нь тогтоох хуулийн зохицуулалттай байгаа.

Х.Ганхуяг: Болсон уу? Тодруулах уу? Бүлэг орд. Тавантолгой асуудлыг хэн хариулах вэ? 8 номер.

Г.Намчинсүрэн: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газар.
Г.Намчинсүрэн.

Тавантолгой орд дээр ашиглалтад одоо Цанхийн зүүн, баруун хэсгүүд ашиглалтад өртөөд явж байгаа. Одоо ашиглалтад өртөх боломжтой, хайгуул судалгааны ажил нь хийгдсэн. Техник, эдийн засгийн үндэслэл нь бэлэн болсон хэсэг Бортээгийн хэсэг дээр байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг Их Хурлын төсөв дагаж байгаа хууль дээр дагуулж орж ирж Үндэсний баялгийн санг арвижуулах асуудлыг тусгасан.

Х.Ганхуяг: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Би дэмжиж байгаа юм. Энэ хуулийн төслүүдийг.

Гэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль энэ орон нутгийн үнэт цаас гаргах асуудал хоёроо хооронд нь яаж уялдуулж барих юм бэ гэдэг асуудал. Энэ өөрөө орон нутгийн өөрийнх нь эдийн засгийн чадамжтай холбоотой асуудал байгаа юм.

Нэг талдаа бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх, тэр тусмаа төсвөөс үе шаттай санхүүжүүлэх түншлэлийн асуудал, орон нутгийн үнэт цаас гаргах асуудал хоёрыг хооронд нь уялдуулж нэг цонхоор харж барихгүй бол энд асуудал үүснэ.

Тэгэхээр энэ хоорондын уялдааг ер нь юу гэж харцгааж байна вэ гэдэг асуудал эрх зүйн хувьдаа би энэ цоорхой үлдээд байгаа юм биш биз гэдэг нэг ийм санаа надад гарч ирээд байгаа юм. Энэ дээр тодорхой хариулт авмаар байна.

Хоёр дахь зүйл нь тэр ашиглаагүй ордыг ашиглах нь зөв өө. Үнэн. Гэхдээ бид хувийн хэвшилтэй хамтарч... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Таны болгоомжилж байгаа тэр эрсдэлтэй шүү гэдэгтэй мянган хувь санал нийлж байна. Одоо бид нарын өөрчлөх гээд байгаа буюу одоо хүчинтэй байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр таны ярьж байгаа эрсдэлүүдийг ер нь бүгдийг нь хаасан байсан юм. Хаасан.

Орон нутаг төр, хувийн хэвшлийн түншлэлээр явахад нэлээн өндөр босготой. Төсөв талаасаа нэлээн бас хяналттай, өндөр босготой, нэлээн эрсдэлийг нь бууруулсан цагт орж болохоор.

Одоо үндсэндээ энэ чинь яг энэ хэлбэрээрээ хэрвээ гуйвуулаад, хэт бас нөгөө тийш нь ашиглаад явах юм бол орон нутгийн ихэнх аймгууд. Одоо чинь 21 аймгаас дөнгөж 7 аймаг нь л татаас авах уу, үгүй юу гээд дэнжгэнэж байгаа байхгүй юу. Бусад 14, 15 аймаг нь татаас авдаг юм. Бүр лав авдаг, лйрын бараг 20, 30 жилдээ бие даах боломжгүй дийлэнх нь ийм аймгууд байгаа. Эдгээр аймгууд маань хүртэл... /минут дуусав/

Х.Ганхуяг: Гүйцээд хариулъя. Б.Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Төр, хувийн хэвшлийн түншлэлээр явах хуулийн боломж нь нээгдэж байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл ирэх жилүүдэд авах татаасаа өнөөдөр бүгдийг нь бөөнд нь авах гээд байгаа юм. Ерөөсөө л тийм юм руу явж орох гээд байгаа юм.

Тийм учраас түүн дээр Засгийн газар, Засгийн газар дотроо Эдийн засаг, хөгжлийн яам төсвийн яамдынхаа үгийг их сайн сонсож явахгүй бол энэ хуулиар хүчиндээд түрээд явах юм бол 2004-2015, 2016 оны хооронд Концессын тухай хууль гэж нэртэй, алдартай хууль байсан үеийн тэр завхрал руу юу юугүй шууд явж орно.

Тийм учраас энэ хуулийн хэрэгжилт дээр Улсын Их Хурал ч тэр, Засгийн газар ч тэр хэрэгжилт дээр маш хянуур ажиллаж явах шаардлагатай хууль болж байгаа шүү гэдгийг хэлье.

Уг нь шат шатад нь Сангийн яамнаас зөвшөөрөл өгдөг, тооцооллуудаа хийдэг, төсвийн эрсдэлийг нь хардаг байсан. Одоо тэр зөвшөөрлүүд нь байхгүй болсон.

Х.Ганхуяг: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр эрх нээгдэж байна.

Тэр нэгжийн хууль, холбогдох хуулиудаар бонд гаргах, орон нутгийн бонд гаргах эрх нээгдэж байгаа юм. Энэ хоёрыг хоёуланг нь нэгтгэж авч үзэж эдийн засгийн чадамжтай нь уяхгүй бол хоёр талд хөрөнгө шийдэх эрх үүсэж байгаа байхгүй юу.

Үүгээрээ дамжаад үндсэндээ орон нутагт нэлээн тийм эргэлзээ үүсэж мэдэхээр ийм юм байгаад байгаа юм. Үүнийг хууль хоорондын нийцэл юмнуудаа хангах, зөв чадамжтайгаа уях асуудлыг анхаарах ёстой. Орон

нутгуудынхаа хөгжлийг дэмжих ёстой. Бид үнэн. Гэхдээ үүнийгээ зөв харах ёстой. Энэ дээр нэлээн сайн анхаарах ёстой шүү. Энэ дээр нэмж тодруулах зүйлүүд, хариулт өгөх зүйл юу байна вэ гэдэг асуудал.

Тэр юуг манай Уул уурхайн яамныхан тодотгоод өгөөдхөөч. Тэр ашиглагдаагүй байгаа нөөцийг ашиглах тал дээр одоо ер нь... /минут дуусав/

Х.Ганхуяг: 7 номер.

Т.Баясгалан: Тийм. Ж.Батжаргал гишүүний асуугаад байгаа зохицуулалтыг Түншлэлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 13 дугаар зүйлийн 4-д оруулж өгсөн байгаа.

Өөрөөр хэлбэл аймаг, нийслэл түншлэлээр төсөл хэрэгжүүлэхдээ хуулийн 14.1.2, 14.1.3-д заасан. Өөрөөр хэлбэл түншлэлийн гэрээнд заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх, эсвэл холимог төрлөөр санхүүжүүлэх энэ тохиолдолд Сангийн яамны зөвшөөрлийг заавал авахаар энэ зохицуулалтыг оруулж өгч байгаа шүү. Тийм. Үүнийг бас хэлмээр байна. Тийм.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд микрофон өгье. Дараа нь 8 номер.

Б.Жавхлан: Яах вэ, одоо байгаа хүчинтэй хууль дээр шат шатанд нь Сангийн яамнаас төсөвтэй холбоотой асуудлуудад зөвшөөрөл авах асуудал байгаа.

7 номерын нөхөр худлаа ярьж байна шүү, чи. Одоо оруулж ирж байгаа хууль дээр чинь Засгийн газраар оруулахад тэртээ тэргүй ямар ч асуудалд тэр Сангийн яам, бүх яамдаас зөвшөөрөл авдаг.

Яах вэ, Сангийн яам, Хууль зүйн яамнаас зөвшөөрөл ирээгүй тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар ордоггүй. Одоо Засгийн газрын хуралдааны дэг өөрөө тийм. Чи тэр зөвшөөрлийг андуурч яриад байна. Наана чинь одоо байдаг. Ямар ч хууль дээр байдаг зөвшөөрөл. Ганцхан энэ хууль дээр биш.

Тэгэхээр энэ хууль дээр тусгайлан оруулсан тийм зөвшөөрөл гэж байхгүй шүү. Байснууд нь бүгд хасагдсан. Одоо хасаж байгаа гэсэн үг. Одоо тэгж худлаа ярихгүй шүү. Их Хурал дээр ороод ингэж худлаа ярихгүй шүү чи хөөе.

Х.Ганхуяг: 8 номер гүйцэд хариул. Тавантолгой ордтой холбоотой асуудал дээр.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Г.Намчинсүрэн. Аж үйлдвэрийн яам.

Ер нь Тавантолгой ордын “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр Тавантолгой ордын нөөцийг “Эрдэнэс

Тавантолгой” хувьцаат компанийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 8.1 тэрбум тонн гэж эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр бүртгэгдсэн байгаа.

Үүнээс бэлэн болсон хэсэг дээр үндсэндээ ил уурхайн хүрээнд 424.2 сая тонн нүүрсийг олборлоод жилд 2-оос 15 сая тонноор ашиглах техник, эдийн засгийн үндэслэл Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр бүртгэгдсэн байгаа.

Х.Ганхуяг: Ер нь асуултаа нэг их сайн ойлгохгүй байна уу. Яагаад хариултаа тодорхой өгөхгүй байгаа юм бэ? Тэр 8 номер гүйцэд хариул.

Г.Намчинсүрэн: Төсвийн хууль дагаж байгаа Их Хурлын төсөл тогтоолын төслийн тухайд энэ уурхайг ашиглах асуудлаар хэлцэл хийгээд тэгээд үр дүнгээ танилцуулаад явна гэсэн агуулгатай орсон байгаа.

Х.Ганхуяг: Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: 2026 оны төсөвтэй холбоотой хэд хэдэн асуудлууд байна. Лавлаж тодруулах асуудал байна. Бид нөхцөл байдалдаа нийцүүлж эдийн засаг, төсөв, санхүүгийнхээ бодлогыг зөв гаргах учиртай.

Тэгэхээр бид энэ удаагийн төсөв дээр бас илүү нарийн төсвөө нэг шүүж, чамбай төсөв батлах асуудал дээр хариуцлагатай хандах ёстой гэж үзэж байгаа.

Зарчмын өнцгөөс асуудалд хандах ёстой.

Тэгэхээр би ямар нэг алдаа төсөв дээр бид гаргаж болохгүй. Энэ дээр хэд хэдэн асуудлууд байна. Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас тодруулж асуулгах зүйл байна.

Төлөвлөлт дээрээ бид яг зөв төлөвлөж чадаж байгаа юм уу? Төлөвлөлт дээрээ. Инфляцыг ирэх онд 7 хувьтай гээд тооцсон байгаа. Түүнтэйгээ уялдуулаад бид цалин хөлснийх нь нэмэгдлийг 6 хувь гээд тооцсон байгаад байдаг.

Гэтэл өнөөдөр “инфляц” өөрөө

→ Улсын хэмжээнд 9 хувьтай болоод байна.

→ Улаанбаатар хотод 9.9 хувьтай болоод байдаг.

Тэгэхээр үндсэндээ төсвийн бодлого өөрөө хэр зөв байна эдийн засгийн бодлого өөрөө тийм байна л гэсэн үг.

Тэгэхээр бид бүхний хувьд зөв төсвийн бодлогыг оруулж ирж байж эдийн засгаа зөв тэлэх, эсвэл хэрэв буруу тооцоолбол эдийн засаг магадгүй уналт руу орох ч ийм эрсдэл байгаа.

Тэгэхээр бид ямар ч бай төлөвлөлт дээрээ хариуцлагатай хандах ёстой. Инфляцаа зөв тооцож байгаа юм уу?

Нөгөө талдаа төсвийнхөө бодлогоор бид

- ▶ Өрхийнхөө бодит орлогыг хэрхэн нэмэгдүүлэх юм?
- ▶ Дундаж давхаргынхаа эзлэх хувийг хэрхэн нэмэгдүүлэх юм?
- ▶ Ядуурлын хувь хэрхэн нэмэгдэх юм?
- ▶ Ядуурлын түвшнээ хэрхэн бууруулах юм?

▶ Эсвэл тодорхой хэмжээнд “тэтгэвэр” болоод “төсвийн бодлого” хэр уялдаатай байгаа юм.

Энэ асуудлууд дээр ямар бодлого барьж байна? Энэ дээр бодлого талаас нь аваад үзэхээр

- ▶ НӨАТ-ын бодлого орж ирж байна.
- ▶ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого орж ирж байна.
- ▶ Үнэт цаас, бонд гаргах эрхийг олгох асуудал орж ирж байгаа.

Том бодлогын түвшинд ямар нэг бодлогын өөрчлөлт алга байна гэж би хараад байгаа юм. Үндсэндээ нийгэм хүсээд байгаа асуудал нь

- татварын суурь шинэчлэлийг сууриар нь бодлогын өөрчлөлтийг хийгээч ээ.
- хувийн хэвслээ дэмжсэн бодлогыг гаргаач ээ,
- эдийн засгийнхаа идэвхжилийг сайжруулах бодлогуудыг хийгээч ээ.
- татвар дээр нь суурь томоохон өөрчлөлтүүдийг хийгээч ээ л гэсэн хүлээлт байгаа юм.

Тэгэхээр энэ дээр эсвэл нэмж Засгийн газар магадгүй илүү том бодлогын татварын өөрчлөлтүүдийг оруулж ирэх юм уу, эсвэл зөвхөн энэ хоёр бодлогоороо 2026 ондоо хязгаарлаж байгаа юм уу?

Эдийн засаг дээр төрийн өрийн дарамт, өр их нэмэгдэж байна. Энэ цаг үе дээр үнэт цаас гаргаж байгаа асуудал зөв юм уу? Хуучин дотоод үнэт цаас гаргах асуудлууд дээр Засгийн газар арай өөр бодлоготой, байр суурьтай байдаг байсан.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

2026 оны төсвийг Засгийн газар байгаа эх үүсвэр, боломжит төсвийн орлого, аль хэдийн энэ бараг зуу зуун хуулиар төсвийг аль хэдийн хуваарилсан, дээрээс нь жилийн төлөвлөгөөнд урсгал зардал 24 хувь байх ёстой гээд. Мөн төсвийн хязгаараар, хүрээгээр хоёр талдаа буурах ёстой гэсэн ийм маш олон хайчин дунд. Өөрөөр хэлбэл цаашдаа ийм олон хайчин дунд төсвийн бие даасан бодлогын орон зай маш багасаж байгаа ийм оны төсвийг төлөвлөөд Улсын Их Хуралд оруулж ирж байгаа.

Ийм үед төсвийн бодлого төгс болсон гэж хэн ч хэлж чадахгүй. Төсвийн бодлого төдийгүй Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирсэн төсвийн хүрээг ч гэсэн төгс орж ирсэн гэж хэлэх боломж байхгүй.

Гадаад нөхцөл байдал маань ямар байгаа билээ.

Тийм учраас бид хамгийн бага эрсдэлтэй түвшинд төсвийнхөө тоонуудыг оруулж ирж байгаа. Бодлогын орон зай улам хумигдаж байгаа гэдгийг би дахин дахин хэлье.

Ингээд оруулж ирсэн төсвийн төлөвлөлт дотор таны хэлсэн параметрууд яаж байгаа талаар би тоонуудаас нь дурдъя.

Инфляцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам ярих ёстой.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирсэн 7 хувь гэдэг инфляц маань мөнгөний бодлоготойгоо нийцэж байгаа. Мөнгөний бодлогын 6 дээр нэмэх, хасах 2 буюу 4-өөс 8 гэсэн ийм **диапазон**¹ дотор багтаж байгаа нь, дээрээс нь эдийн засгийнхаа өсөлтийг мөн 5.7 дээр дэмжиж, мөн Монголбанктайгаа үүнийгээ уялдуулж орж ирж байгаа нь өөрөө **“мөнгөний бодлого”**, **“төсвийн бодлого”**-ыг нийцүүлж орж ирж байгаа бодлогын илрэл гэж харах хэрэгтэй.

Төсвийн энэ олон хязгаарууд дотор цалингийн өсөлт, тэтгэврийн өсөлт инфляцыг гүйцэж чадахгүй.

Инфляцыг бас хэт их гүйцээж, эсвэл давуулж тавих нь өөрөө дахиад эдийн засгийг эрэлт талаас нь өдөөх өндөр эрсдэл байдаг.

Тийм учраас хуулиар үүрэг өгсөн бид нарын хамгийн нэгдүгээрт харах ёстой тэтгэврээ л бид 6 хувиар нэмж оруулж ирэх төсвийн орон зай л энэ дотор байна гэсэн үг.

Тийм учраас цалинг хөндөх боломж, орон зай байсангүй гэдгээ хэлье.

Төсөв, мөнгөний бодлогыг хэлсэн. Том бодлогын зорилт нь. Тийм ээ. Том бодлогын зорилт маань төсвийн өсөлтийн хязгаарыг бид хумьж чадсан.

¹ Хүүгийн хэлбэлзэх хүрээ, хязгаар, интервал

Төлөвлөгөөнөөсөө эхлээд. Төлөвлөгөө 24 хувь дээр байх ёстой шүү гэдэг бол энэ маш том хязгаарлалт болж байгаа.

Мөн төсвийн хүрээний хувьд ч тэр одоо бид хоёр талаас нь бууруулж орж ирж байгаа нь бас нэлээд том бодлогын эргэлт алхам болж байгаа гэж бодох ёстой.

Тийм ч учраас энэ салбарууд дээр маш хүнд тусаж байгааг Та бүхэн эхнээс нь харж байгаа. Гэсэн хэдий ч бид үүнийг цааш нь дасан зохицох ёстой.

Тэгэхдээ дасан зохицохын тулд цаашдаа бид маш хатуу өвдөлттэй бодлогын шийдвэрүүдийг гаргах ёстой. Тэр нь өнөөх л нөгөө зуу зуун хууль дотор хийсэн байгаа аль хэдийн баталсан төсвүүд байгаа. Тэрийг бид оролдохгүйгээр цаашаагаа үүнийг явах боломж маш хязгаарлагдмал болж ирж байна гэдгийг хэлье.

Татварын суурь өөрчлөлт. Татварын суурь өөрчлөлт 90 оноос хойш хамгийн том өртөгтэй, хамгийн том олон параметруудийг хөдөлгөсөн, олон далайцтай нэлээн том тийм сууриар нь өөрчилж байгаа. Төсвийн цогц хөтөлбөрийг бид эхлүүлж байгаа.

Нэг доор бид 8 их наядын өөрчлөлттэй татварын өөрчлөлтийг бид хийж чадахгүй. Параметрууд нь уг нь орлого талдаа 4 их наядын өөрчлөлт өгч байгаа юм. Одоо төсөв дээр тийм дарамт ирж байгаа гэсэн үг.

Энэ маань яг төсөвт тусах... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд гүйцээгээд хариулъя.

Б.Жавхлан: Орон нутгийн татаас болоод, ингээд хоёр талдаа эффект өгөөд 7-гоос 8 их наяд. Магадгүй 3 жилийн хөтөлбөр дээр энэ инфляцтай холбоотой дүнгүүд бүр өндөр болохыг ч үгүйсгэхгүй.

Тийм учраас 2026 онд орлого багасаж байгаа, гадаад нөхцөл байдал хүнд байгаа үед бид дааж чадах хэмжээнд буюу, мөн нөгөө талаасаа хамгийн их эрэлттэй, хамгийн их саналтай байгаа НӨАТ, НӨАТ-ын буцаан олголтоор эхэлж байгаа.

Энэ нь хоёр талын үр ашигтай. Мэдээж аж ахуйн нэгжүүд дээр мөн тодорхой арга хэмжээнүүдийг, өөрөөр хэлбэл мөнгөн суурьтай ACCRUAL суурьтайгаар байгаа шилжилт хийж эхэлж байна.

Иргэд дээр өрхийн орлого дээр бодитой дэмжлэг болохоор. Дээрээс нь эдийн засгийнхаа НӨАТ-ын татварын суурийн бүртгэлийг сайжруулах талдаа нэлээдгүй үр дүнтэй арга хэмжээ болно.

Тийм учраас бид... /минут дуусав/

Х.Ганхуяг: Г.Тэмүүлэн гишүүн тодруулах уу? Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Би харин энэ төсвийн бодлого дээр төлөвлөлт дээр чинь алдаа байна гэдэг асуудлыг яриад байгаа юм.

Нэгдүгээрт, наад инфляцтай холбоотой асуудал ирэх жил 7 хувь байна гэдэг чинь бас л худлаа яриад байгаа асуудал болоод байна шүү дээ.

Өнгөрсөн жил Та бүхэн чинь өөрсдөө оруулж ирэхдээ энэ жилийн инфляцыг 6-аас 7 хувьтай байна гэсэн. Гэтэл өнөөдөр Улаанбаатар хотод бодит инфляц 10 хувьтай байна. Улсын хэмжээнд 9 хувьтай байна.

Ийм юм болно гэдгийг чинь өнгөрсөн жил бид төсөв баталж байхад хэлж байсан шүү дээ. Бодит нөхцөл байдал хүнд болох гээд байна. Тэр үед бид төсвийнхөө бодлогыг зөв болгоё гэдэг асуудлыг хөндөж яригдаж гарч ирж байсан.

Одоо өнөөдөр нүүрс дээр ч гэсэн аваад үз л дээ. Та хэд дахиад л хэдэн саяар гээд л тооцоолоод л өөдрөгөөр төсөөлөөд л гаргаад ирсэн. Үнээ яах вэ, харьцангуй 70-аар тооцсон байгаа. Гэхдээ энэ чинь үүнд хүрэх боломж бололцоо байхгүй болоод байна шүү дээ.

Алтны үнэ өөрөө 4100 гараад явлаа. Энэ чинь өөрөө сайны дохио биш. Эдийн засаг өөрөө нөхцөл байдал сайнгүй болохоор байна гэдэг зүйлийг гаргаж ирээд байхад энэ дээр жоохон бодитоор хандаж болдоггүй юм уу? Энэ тооцооллоо зөв хийж болдоггүй юм уу? Инфляцаа зөвөөр тооцож болдоггүй юм уу? Эдийн засгийнхаа энэ өсөлтийг... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Энэ инфляцынхаа тооцоолол дээр Эдийн засаг, хөгжлийн яамныхан дуугараарай.

Инфляцыг тооцоолдог философийг Г.Тэмүүлэн гишүүн ээ ингээд ойлгох хэрэгтэй шүү. Монголбанкны мөнгөний бодлогын төсөөлөл яригдана.

Тэгэхээр төрөөс инфляцыг онилж байгаа бодлогын зорилт маань өөрөө хойтон бид инфляция алдах нь ээ, тэд болох нь ээ, 10 болох нь ээ.

Тэгэхээр 10-аар нь тавъя гэдэг ийм тооцоолол биш шүү дээ. Энэ чинь зорилтот түвшин байхгүй юу.

Одоо Монголбанкны 6 хувийн голчтой зорилтот түвшин диапозон нь одоо нэмэх, хасах 2 гээд 4-өөс 8 гэж байгаа юм.

Бид мөнгөний бодлогынхоо бүх хэрэгсэл, зорилт, бүхий л боломжуудаа MACROPRUDENTIAL². Ерөөсөө бүх бодлогуудаа энэ рүү чиглүүлнэ гэдэг зорилтот түвшин байхгүй юу.

Зорилтот түвшиндээ хүрэхгүй гүйцэтгэл ямар гарах нь дараагийн асуудал.

Тийм учраас Засгийн газар Монголбанканд 6 хувийн голчтой гэж үзэж байгаа бол Засгийн газар... /минут дуусав/

Х.Ганхуяг: Гүйцээгээд хариулья.

Б.Жавхлан: Инфляцын голч нь 7 байх нь.

Энэ рүүгээ бид бодлогоо чиглүүлнэ гэдэг ийм зорилтот түвшин байхгүй юу. Түүнээс энэ чинь гүйцэтгэл биш. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлого хатуу төлөвтэй хумьж орж ирж байгаа. Түүнтэй ижилхэн бид ерөөсөө төсвийн хүрэн дээрээ ч гэсэн бүх тоонуудаа хоёр талаас нь хумьж орж ирж байна.

➔ Зардлаа хумьж орж ирж байна.

➔ Орлогоо хумьж орж ирж байна.

Ингээд мөнгөний хатуу бодлоготойгоо бид нийцэж байгаад зорилтот түвшин рүүгээ фронтоороо цуг явж байгаа байхгүй юу.

Гүйцэтгэл тусдаа гарна. Гүйцэтгэл диапозон дотроо гарсан уу, үгүй юу гэдэг дараагийн асуудал юм.

Нүүрс дээр Засгийн газар ажил хийе л гэж байгаа. Энэ жил ер нь 80-аас 85-ын хооронд гарна. Тэгэхээр 5 сая тонны л зөрүү байгаа юм. Сая бид түүхэндээ хамгийн өндөр буюу 8 сард 8.5 сая тонн дангаараа гаргалаа. Дангаараа. Тэгэхээр хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар нь энэ хэмжээнд хүрсэн байна. Урд эрэлт байна уу, юу л байна. Бидэнд нүүрс нь байна уу, байна.

Тэгэхээр энэ хэмжээ харин ч бодитой бөгөөд үүнээс давуулж гарах ёстой гэдэг л... /минут дуусав/

² Санхүүгийн системийн тогтвортой байдалд чиглэсэн төрийн бодлого. Мөнгөний бодлогоос ялгаатай нь зөвхөн инфляци биш, харин эрсдэл, санхүүгийн хөөсрөлт, банкны салбарын тогтвортой байдал зэрэгт төвлөрдөг. Зорилго нь нэг байгууллага биш, бүх системийн эрсдэлийг хянах явдал.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофон өгье.

Б.Жавхлан: Алт бол яг “төсөв”, “мөнгөний бодлого”, “валютын нөөц” дээр арай өөр өөр үүрэг гүйцэтгэдэг байгаа юм. Нүүрснээс арай ялгаатай.

Нүүрсний бодит хэмжээ, алтны бодит хэмжээ хоёр төсөв дагасан эдийн засгийн дэмжлэг, эдийн засгийн өсөлтийн BOOST_[идэвхжүүлэх, түргэсгэх] хийх дээр:

- **Алт нь** нөөц талаараа, валютын нөөц талаараа илүү их дэмжлэг үзүүлнэ.
- **Нүүрс нь** цэвэр эдийн засаг, тээвэр ложистик, уул уурхай гээд маш олон салбараар шууд буюу шууд бус замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлдэг байгаа юм.

Тэгэхээр алт нь 20 тонн гэдэг бол бас тийм бид нарын хүрч чадаагүй хязгаар биш. Бид хамгийн максимумдаа 24 хүрч байсан юм. 24 хүрч байсан. Сүүлийн жилүүдэд 15-аас дөнгөж давж байгаа.

Тэгэхээр энэ жил 7, 8 орчим гарч байгаа юм байна. Ингээд дөрөвдүгээр улиралд нэлээдгүй энэ нь нэмэгддэг. Монголбанкныхан байвал хэмжээгээ, энэ жилийн гүйцэтгэлээ хэд байгаа юм. Тийм. Уул уурхайнхан бас энэ дээр хэлээрэй. 7, 8 хоёр тоо.

Тэгээд хойтон... /минут дуусав/

Х.Ганхуяг: Уул уурхайн яам. 8 номер.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад нэмж тайлбар өгье. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн.

Алтны тухайд олборлолтын хэмжээ буурч байгаа нь үнэн. Энэ маань үндсэндээ шороон ордуудын нөөц үндсэндээ шавхагдаж байгаатай холбоотой.

Бид үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах л чиглэлээр холбогдох ажлууд хийж гүйцэтгэнэ гэж төлөвлөж байгаа.

Үндсэндээ Монгол Улсын хэмжээнд нөөц нь бүртгэгдсэн 100 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаа. Үндсэн ордын. Тэгээд цаашид энэ ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр ажиллана. Тэгээд Засгийн газрын зүгээс “Алт-3” гээд аяныг зарлаад явж байгаа. Энэ хүрээндээ ажлын төлөвлөгөөнүүд гаргаад ажиллаж байгаа.

Х.Ганхуяг: Г.Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Би энэ алт дээр яриад байгаа асуудал бол алт өсөөд байна гэдэг чинь сайны дохио биш ээ л гэдэг зүйлийг яриад байгаа байхгүй юу. Долоо

долоо хоногоор энэ чинь нэг унци алтны үнэ чинь 100 доллароор нэмэгдээд байна шүү дээ. 4 мянга өнгөрсөн долоо хоногт байсан бол өнөөдөр 4100 болсон байна.

Цаашдаа энэ чинь хэд хүрэхийг ч бид тооцоолж мэдэхгүй болоод байдаг. Наад алтны чинь бүх нөөцийг бүрдүүлж байгаа үндсэн 4 улс буюу Хятад, Америк, Герман, Итали эд нар чинь бүгд өөрсдөө алтныхаа нөөцийг нэмэгдүүлээд байна шүү дээ. Энэ чинь сайны дохио биш шүү дээ. Эдийн засгийн хямралын дохио байхгүй юу.

Тэгэхээр бид ийм нөхцөл байдал дээр эдийн засаг өөрөө дэлхийн түвшиндээ тогтворгүй тогтворгүй байхаар байна, инфляц нэмэгдэхээр байна, долларын чинь ханш унахаар байна гэдэг энэ зүйлүүд дээр ч гэсэн бид дүгнэлт хийгээд төсвөө нэг жоохон чамбай хийе л гэдэг асуудлыг яриад байгаа шүү дээ.

Гэтэл үндсэндээ өнөөдөр долларынхоо ханшийг ч гэсэн Та хар л даа. 3600 болсон. Энэ зах зээл дээр доллар нь өөрөө олдохоо больсон. Дэлхий даяар долларын ханш унаад байхад манайд долларын ханш өсдөг ийм урвуу хамааралтай улс орон гэж бараг байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ чинь эдийн засгийн бодлого нь, төлөвлөлт нь өөрөө буруу байна гэдэг асуудлыг би хөндөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр дахиад та нар дөргүй бух шиг, буруу ишилсэн сүх шиг... /минут дуусав/

Х.Ганхуяг: Үг хэллээ. Д.Пүрэвдаваа гишүүний микрофон өгье.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Дагасан хууль дотор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн танилцуулга дээр 2026 онд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөнд 4.4 их наяд төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна гээд бичсэн байна.

Энэ жилийн хөрөнгө оруулалт чинь 3 их наяд биз дээ. Тэгээд 4.4 их наяд төгрөгийг 12 төсөлд гэхээр нэлээн том 12 төсөл байна. Энэ 12 төслөө нэр цохож байршилтай нь, дүнтэй нь яаж сонгон шалгаруулсныгаа маш товчхон хэлмээр байна.

Дараагийнх нь зүйл. Улаанбаатар хот болон 21 аймагт, дээрээс нь энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын доор байдаг орон нутгийн өмчит 400-аад компани байгаа. Тэгээд л нэг ийм ашигтай, ашиггүй ажилладаг АЗЗА-нууд байдаг. Эд нарыгаа ирэх жилүүдэд бизнесийнхийгээ дэмжээд төр, хувийн хэвшлийнхээ тэр нөхцөл рүү үе шаттайгаар оруулж байгаа юу? Энэ жил тэр 400

компанид хэдэн төгрөгийн төсөв тавьсан юм? Хэчнээн хүн цалин авах юм? Тэр мэдээллийг товчхон өгөөч гэж хэлье.

Дээрээс нь төрийн өмчит ашиггүй ажиллаж байгаа компаниудынхаа асуудал дээр. Зөв үү? Та бүхэн маань энэ ойрын дунд хугацааны төлөвлөгөө чинь энэ 5 жилдээ яаж төсөөлсөн юм? Жил болгон хэдэн төгрөг зарцуулдаг байж байгаад тэрийгээ үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа юм уу, эсвэл багасгаж байгаа юм уу гэдэг мөнгөнийхөө бодлогыг хэлмээр байна.

Тэгээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр татвар 1 хувьд нь тооцуулаад сургууль, цэцэрлэг барина гээд бас нэг төсөл орж ирж байсан. Хэдэн цэцэрлэг, сургууль баригдахаар болов? Тийм ээ. Татвар төлөх 1 хувьдаа компаниуд цэцэрлэг, сургууль барьж болно гэсэн нэг ийм төсөл явж байсан. Энэ одоо яг ямар үр дүнтэй байгаа юм? Ирэх жил тэр 1 хувиар хэчнээн сургууль, цэцэрлэг баригдахаар хаана төлөвлөгдөв? Тийм үү?

Ингээд бусад дэлхийн орнуудыг харахаар хувийнхны хийж чадах ажлуудыг ер нь төр хийхгүй байх гэдэг дээрээ маш хатуу байгаа. Та бүхэн маань энгийн хог тээврээс авхуулаад, энэ зам засахаас авхуулаад үүнийгээ яаж шилжүүлж байгаа юм бэ гэдэг журамласан үе шатаа хэлээч гэж хэлмээр байна. Тэгээд тодруулъя.

Х.Ганхуяг: 7 номер. 7 номерын микрофоноо өгье. Уул уурхайн яам Төрийн нарийн бичгийн дарга аа дууд. Аан. Эдийн засаг, хөгжлийн яамны сайд ороод ирсэн байна.

Н.Учрал сайд аа, гишүүд асуулт асуугаад байна. Энэ долларын ханш унаад байна, алтны үнэ өсөөд байна. Энэ нь Монгол Улсад инфляцад хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдэг асуултыг удаа дараа тавиад байна. Энэ дээр Н.Учрал сайд хариултаа бэлдэж байгаарай. 7 номер.

Т.Баясгалан: Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нийт 316 төсөл тусгагдсанаас 12 төсөл буюу энэ заавал улсын төсөвтэй холбоотой биш л дээ. Д.Пүрэвдаваа гишүүн ээ.

Нийтдээ энэ төслүүдийнх нь төсөвт өртөг, тооцоолол нь 4.4 их наяд төгрөгийн томоохон төслүүд байгаа юм. Жишээлбэл, одоо энэ дээр би хэлбэл

- ▶ Дархан-Уул аймгийн Шарын гол суманд 50 мегаваттын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх.
- ▶ Гурвансайхан нисэх буудыг 4D ангилал болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах.
- ▶ Ханги, Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам барих.
- ▶ Арцсуурь, Шивээхүрэн, Нарийнсухайт чиглэлийн 1255 километр

төмөр замыг барих гээд ийм 12 төсөл байгаа.

Энэ жагсаалтыг би танд хүргүүлж болно.

Тэгэхээр хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 126 төсөл, арга хэмжээнээс 76 төсөл, арга хэмжээг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусаад, 50 төсөл, арга хэмжээ нь санхүүжилтийн эх үүсвэргүйгээс болоод орхигдсон байгаа.

Тийм учраас эдгээр төслүүдээс урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх замаар түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой, тохиромжтой гэсэн төслүүдийг түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Саяын таны хэлдгээр тэр аймаг, нийслэл дээр аймаг болгон дээр түншлэлийн асуудал хариуцсан орон нутгийн өмчит үйлдвэрийн газар юм уу, компани байхгүй байгаа.

Харин Нийслэлийн Засаг даргын харьяанд “Улаанбаатар түншлэлийн төв” гээд нийслэлийн өмчит үйлдвэрийн газар ажиллаж байгаа. Энэ үйлдвэрийн газар нийслэлийн хэмжээнд хэрэгжих төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх 30 гаруй төслүүдийн жагсаалтаа боловсруулаад Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаад эхнээсээ төслүүд нь сонгон шалгаруулалтаа зарлаад, “хог шатааж эрчим хүч гаргах төсөл” болон “5 дугаар цахилгаан станц”-ын төсөл дээр гүйцэтгэгчийг нь сонгоод, хэлэлцээ хийх шатандаа явж байгаа ийм байдалтай байгаа.

Аймгуудад ийм түншлэлийн төв байгуулах зайлшгүй шаардлага байхгүй гэж харж байгаа. Тийм.

Х.Ганхуяг: Тодруулъя. Д.Пүрэвдаваа гишүүний микрофон өгье.

Д.Пүрэвдаваа: Үгүй ээ. Хариулсангүй л дээ. Би дахиад хэлээд байгаа шүү дээ.

Нөгөө ашиггүй ажилладаг 400 компанидаа 2026 онд хэдэн төгрөг төсөвлөсөн юм бэ? Хэдэн хүн цалин авах юм бэ? Тэгээд энэ бизнесийн орчноо дэмжээд, энэ хувийн хэвшлийнхэн хийж чаддаг ажлыг тэр 400 компаниараа алдагдалтай ажиллуулж байхаар үе шаттайгаар тэр эрхийг нь шилжүүлж болдоггүй юм уу?

Энэ асуудлыг ямар дүрэм, журмаар, ямар хэм хэмжээгээр зохицуулахаар төлөвлөж байгаа юм бэ? Маш ойлгомжтой асуусан шүү дээ. Тэгээд тэр 1 хувийн хэчнээн сургууль баригдсан юм.

Дээрээс нь би асууж байна.

- Энэ 12 төсөл чинь яагаад энэ танилцуулга дээрээ тусгагдахгүй байгаа юм?
- Эзэн бие нь хаана байгаа юм?
- Сонгон шалгаруулсан үе шат нь хаана байгаа юм?

Х.Ганхуяг: 7 номер гүйцээгээд хариулъя.

Т.Баясгалан. Тэр 400 компанид ажиллаж байгаа ажилтнуудын төсөв, цалинтай холбоотой асуудлыг Сангийн яам хариулах байх гэж бодож байна.

Боловсролын сайдаас боловсролын салбарт төр, хувийн түншлэлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн саналыг Боловсролын яамнаас судалж байгаа. Тэгээд асуудлыг манай яамаар дамжуулаад “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”-д тавиад хамтраад ажлын хэсэг байгуулаад, үнэлгээ хийгээд, түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх асуудлыг зөвхөн судалгааны шатад явж байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр сургууль, цэцэрлэг барих ажил өнөөдөр эхлээгүй байгаа.

Д.Пүрэвдаваа гишүүний асуугаад байгаа тэр 12 төслийн хувьд ч гэсэн зарим нисэх буудлуудыг барих, сайжруулах ажлууд дээр урьдчилсан үнэлгээ хийгээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь оновчгүй юм байна гэдэг ийм дүгнэлт нь гарсан байгаа.

Түүнээс энэ дээр сонгон шалгаруулалт зарлаад, гүйцэтгэгчийг сонгосон, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн... /минут дуусав/

Х.Ганхуяг: Д.Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Би тараасан материалыг л асууж байгаа юм шүү.

Энэ жил чинь 3 их наяд төгрөгийн л бид хөрөнгө оруулалтын төсөвтэй байхад 4.4 их наяд төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан гээд бүр тодорхой бичсэн байна шүү дээ.

Та бүхэн маань үүнийг чинь. Би үүнийг чинь хэрэгжинэ ээ л гэж ойлгож байгаа шүү дээ. Тийм биз дээ? Тэгээд нөгөө талдаа бид яриад байдаг. Нөгөө төсвийн мөнгөө хэмнээ. Энэ жил чинь хамгийн их урсгал зардлыг хэмнэнэ гэсэн жил мөн биз дээ?

Тэгээд тэр ашиггүй ажиллаж байгаа 400 компаниа ядаж 200 болгоод, 200-г нь тэр бизнесийн чаддаг хүмүүсээр нь хийлгэж болдоггүй юм уу? Нийслэлд л лав 60 компани л байдаг байсан санагдаж байх юм. Одоо бараг 100 болсон

байх. Аймаг, дүүрэг болгонд л 5-аас 10 компани байгаа шүү дээ. Үүнийг тэгээд хэн нь хариуцаж байгаа юм?

Х.Ганхуяг: 9 номер. И.Батхүү. 7 номер хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамныхан жоохон асуудлыг тодорхой хариулахгүй бол нэг юмаа гурав, дөрөв асуугаад байна шүү дээ.

Т.Баясгалан: Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Д.Пүрэвдаваа гишүүн ээ, ийм байхгүй юу. Одоо жишээлбэл энэ түншлэлийг хэрэгжүүлэхээр жилийн төлөвлөгөөнд туссан нь үнэн. Гэхдээ энэ дээр өнөөдрийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар хувийн хэвслээс юм уу, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох яамдаас санал нь гарч ирэх ёстой. Тэгтэл эдгээр төслүүдийг өнөөдөр хэрэгжүүлье гээд саяын таны хэлээд байгаа 12 төсөл дээр зарим төслүүд дээр нь санал нь ирээд, урьдчилсан үнэлгээгээр түншлэлээр хэрэгжүүлэх боломжгүй гээд 4 нисэх буудлын төсөл дээр нь дүгнэлт гараад байгаа.

Зарим төслүүд дээр нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар санал нь гарч ирээгүй болохоор шууд хэрэгжүүлээд явах тийм сонгон шалгаруулалт зарлах ч юм уу, ийм эрх зүйн зохицуулалт байхгүй учраас заавал салбарын яамдын санал болон хувийн хэвшлийн түншлэгчийн саналыг хүлээгээд тэгээд энэ дээрээ саналаа ирүүлэхгүй байх юм бол манай яамнаас “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” рүү судалгаа хийлгэх, шинжилгээ хийлгэх ажлууд нь хийгдэхгүй хүлээгдэж байгаа.

Х.Ганхуяг: Д.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Хоёр асуулт байна.

Нэг нь, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол.

Тэгэхээр үүнийг өмнө хуралдаануудаар асуусан. Миний ойлгож байгаагаар төсөвт нэг их шууд нөлөө багатай юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр үүнийг энэ удаадаа үүнийг хойшлуулвал яасан юм бэ. Яагаад вэ гэхээр энэ доторх заалтууд нь ер нь их л олон юм хольсон ийм дүр зургууд харагдаад байна л даа. Өмнөх гэрээнүүдээс ололттой юм нь болохоор ил тод, нээлттэй явуулна гэсэн байгаа юм. Тэгээд энэ танил танилцуулгаас харахаар том дүнтэй л биржийн арилжаа хийх гэж байгаа юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр үнэ бага байгаа үед ийм том дүнгээр гэрээ хийнэ гэдэг бол одоо бас л л оптек гэрээтэй л адилхан ийм л агуулга орж ирж байгаа.

Тэгэхээр ялангуяа зах зээлийн үнэ ийм бага үед нэгдүгээрт хүн орж ирэх үү, үгүй юу?

Хоёрдугаарт, бид нарын хувьд тийм ашигтай байх уу, үгүй юу? Уг нь илүү зах зээлийн үнэ өндөр байх үед жишээлбэл ийм урт хугацааны үнэ тогтворжуулах ийм гэрээ хийвэл илүү зүгээр байдаг.

Тэгэхээр бага үед нь ингэж хийхийн оронд бараг энэ шаардлагатай санхүүжилтээ хямд үнэтэй зээлийн санхүүжилтээр энэ мөнгөө босгоод, тэндээс нүүрсний борлуулалтаас орж ирэх орлогуудаараа буцаад үүнийгээ төлөөд явсан нь илүү жишээлбэл энэ зорилтод нийцэх юм шиг харагдаад байна л даа.

Дээр нь эрчим хүчний нүүрснийхээ асуудлуудыг, ерөнхийдөө юмнуудыг холиод бичсэн.

Тэгэхээр биржийн арилжаа гэдэг чинь спот маягтай. Өөрөөр хэлбэл богино хугацааны зах зээлийн нөхцөл байдалд тааруулдаг арилжааг том дүнтэй хэд хэдэн удаагийн 1 тэрбум долларын 3-аас 5 удаагийн арилжаа хийнэ гэсэн танилцуулга байна. Энэ тэгэхээр биржийн арилжаа гэдэг хэлбэртэй боловч яг бодит мөн чанар нь оптек гэрээ болохоор байна. Тэгээд хямд үед бас үнээ хямдхан өгөх ийм асуудал үүсэх гээд байна.

Дээр нь тээвэрлэлттэй холбоотой, уурхайтай холбоотой асуудлыг нь хөрөнгө оруулагчид санал тавина гээд байгаа юм.

Тэгэхээр энэ харилцаа чинь өөрөө өмнө ярьж байсан бид Монголд үлдээх, Монгол компаниуд боломж олгох, бид экспорт хийж байгаа юм бол аль болох хүргэх цэгээ тэр хэрэглэгчид нь дөхүүлж өгөх ёстой болохоос биш энэ чинь бараг экспорт биш дотоодын борлуулалт шахуу л ийм юм хэдүүлээ болоод байна шүү дээ.

Тэгэхээр энэ баялаг бий болгоно гэдэг чинь тэр хүргэх цэгийг аль болохоор эцсийн хэрэглэгчдэдээ хүргэж байж илүү үнэ цэн бий болгодог.

Тэгэхээр энэ бол яг мөн чанар нь, гэрээнүүд нь хоорондоо, танилцуулгууд нь хоорондоо зөрчилдөөд байгаа учраас илүү сайжруулаад, дахиад оруулж ирээч ээ гэсэн ийм зүгээр санал байна. Энэ дээр ямар бодолтой байгаа юм?

Хоёрдугаарт нь, НӨАТ-тай холбоотой асуудал байгаа. НӨАТ-тай холбоотой асуудал дээр өмнө нь бас хэлсэн. Татвар ногдуулалт. Ялангуяа НӨАТ ногдуулалт... /минут дуусав/

Х.Ганхуяг: Татвартай холбоотой асуудлыг нь Б.Жавхлан сайд хариулъя.

Уул уурхай яамны тэр сайд нь юм уу, Төрийн нарийн нь ирэхгүй бол энэ хэлэлцүүлэг хойшлууллаа шүү. Энэ асуудал дээр чинь Уул уурхайн асуудал

нэгдүгээр асуудал байна. Эдийн засаг, хөгжлийн асуудал хоёрдугаар асуудал. Төсөв гээд л гуравхан л асуудал байна шүү дээ. Тэгээд ямар учиртай хэдэн удаа дуудуулах гээд байгаа юм бэ?

Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Гишүүн ээ, юу шүү. Төсөвт бас огт хамаагүй ч зүйл бас биш шүү. Холбоотой байлгүй яах вэ. Энэ чинь үндэсний баялгийн сангаа л бид арвижуулах гэж байгаа асуудал. Үндэсний баялгийн сангийн төсөв маань өөрөө улсын нийт төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь байгаа юм. Үүнийгээ л баяжуулах гэж байгаа. Ард түмний баялгийг л өсгөх гэж байгаа. Одоо байгаа энэ боломжуудаа хэдхэн жилийн бид энэ цонх үедээ яаралтай бид хөндөж чадаагүй байгаа хэсгээ эргэлтэд оруулъя гэж байгаа юм.

Түүнээс биш биржээр явах гэж байгаа “spot арилжаа”³-ны асуудал ерөөсөө огт биш шүү. Энэ чинь эргэлтэд оруулаад тэр гүнд байгааг байгалийн баялаг болгож гаргаж ирээд, тэгээд тэрийг тээвэрлэхэд бэлэн болсон үед л энэ чинь биржээр явна шүү дээ. Арилжаа нь. Гэтэл тэр чинь ерөөсөө газраа ч хөндөөгүй байгаа асуудал байхгүй юу.

Тийм учраас бүхэлд нь үүнийг эргэлтэд оруулах асуудал л энэ тогтоолоор яригдаж байгаа асуудал байгаа юм шүү.

Уул уурхайн яамныхан баяжуулна биз дээ? Тийм ээ. Бид ийм зорилгоор энэ саналыг дэмжиж, энэ тогтоол зайлшгүй хугацаа алдахгүй 2026 оны төсөв дээр оруулж ирэх ёстой юм байна гээд.

Энэ жил маш цомхон, 4-хөн асуудал дагаж байгаа. Тэрний нэг нь байгаа юм. Маш чухал 4 асуудал л гэж харж байгаа. Ерөөсөө топ 4 асуудлаа л оруулж ирж байгаа.

Түүнээс биш ер нь 40 асуудал яригдана шүү дээ. Үүнийг дагуулж оруулж өгөөч ээ гээд.

Х.Ганхуяг: Танайхан ирэх юм уу, ирэхгүй юм уу? Байнгын хороо цаг 20 минут хүлээж байна шүү дээ. 8 номер гүйцээгээд хариулъя.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Үндсэндээ ордыг сорчлохгүй олборлох тал дээр бид салбарын яамны зүгээс анхаарлаа хандуулж ажиллаж байгаа.

³ “Спот арилжаа” гэдэг нь санхүүгийн хэрэгслийг одоогийн зах зээлийн үнээр, даруй худалдан авах, эсвэл зарах үйл явцыг хэлнэ.

“Эрдэнэс Тавантолгой” дээр сүүлийн 3 сарын хугацаанд онцгой дэглэм тогтоосон.

- Энэ хүрээнд нийтдээ 5.9 сая тонн нүүрс экспортод гаргаснаас
 - 2.9 сая нь кокс эрчим хүч.
 - 2.1 сая буюу гуравны нэг коксжих нүүрсийг экспортод гаргасан байгаа.

Цаашид энэ ордыг иж бүрэн ашиглах тал дээр анхаарлаа хандуулаад ажиллана гэж үзэж байгаа.

Х.Ганхуяг: Байж байгаарай. Татвар дээр сая НӨАТ-ын татвар асуусан юм. Тэрийг нь та хариулах уу? Одоохон. Хариулчхаад дахиад тодруулчих.

Б.Жавхлан: НӨАТ-тай холбоотой асуудал дээр хэрвээ тэр 10-ыг 5 болгох юм бол энэ маш цамаан бөгөөд үрэлгэн, маш буруу бодлого болно.

Энэ олон улсын НӨАТ-тай холбоотой өөрчлөлт, шинэчлэлийн чиг хандлага ерөөсөө прогрессив шинжтэй энэ чиглэл рүүгээ л явж байгаа. Өөрөөр хэлбэл энэ маань өөрөө аж ахуйн нэгжүүдийн төлдөг татвар биш. Эцэстээ. Энэ бол хэрэглэгчийн төлдөг татвар.

Аж ахуйн нэгж дээр асуудал үүсээд байгаа гэдэг маань ерөөсөө процессын алдаа байна. Яагаад вэ гэхээр энэ нь мөнгөн суурьтай биш. Нэгдүгээрт. Урьдчилж аваад байдаг. Тэр нь мэдээж аж ахуйн нэгжүүд дээр дарамт болоод байна. Ялангуяа хил дээр.

Дээрээс нь дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг, агентын үүрэг гүйцэтгэдэг аж ахуйн нэгжүүд дээр НӨАТ-ын дарамт ирж байна гэдэг маань маш олон. Бид тоолсон. Бүр 50 хуулиар 50 тодорхой бараа, бүтээгдэхүүн дээр НӨАТ-ын чөлөөлөлт хийхээр энэ нь яг шударгаар агент хийгээд явж байгаа аж ахуйн нэгжүүд дээр бараг рояалти шиг, татвар шиг болж очоод байгаад л асуудал байгаа юм.

Х.Ганхуяг: Д.Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Татварын асуудал дээр харин саяын тэр ногдуулалт болон хураалттай холбоотой асуудлуудаа цуг оруулж ирэхгүй бол энэ чинь буцаад бизнес эрхлэгчдэд дарамт болох гээд байна.

Тэгээд хавсралтын хэсэг дээр нь “татвар хураалтыг сайжруулна”, “татварын өрийг бууруулна” гээд. Жишээлбэл, өр барагдуулалтын хувь өнгөрсөн онд 35 хувь байсан бол одоо 50 хувь болгож нэмэгдүүлнэ гээд.

Тэгэхээр НӨАТ-ын орлого жишээлбэл 380 орчим тэрбумаар нэмэгдэхээр байна лээ л дээ.

- ▶ Үүний хэд нь энэ хураалтаас байгаа юм?
- ▶ Хэд нь энэ татварын өөрчлөлтөөс байгаа юм? гэдэг тоо хэлж өгөөч.

Хоёрдугаарт нь, саяын тэр “Тавантолгой”-той холбоотой асуудал дээр дэмжиж байгаа юм. Гэхдээ гол нь зөв болгож хийе ээ л гээд байгаа юм.

Тэгэхээр одоо энэ орж ирж байгаа асуудал чинь болохоор үзэл баримтлалаасаа зөрөөд байгаа байхгүй юу. Энэ дээр “нээлттэй биржийн арилжааг дэмжинэ”, “нээлттэй болгоно” гэсэн мөртлөө энэ буцаад өөрөө оффтейкийн шинжтэй ийм л юу харагдаад байна л даа. Тайлбар, үзэл баримтлал хоёр жоохон зөрөөд байгаа харагдаад байгаа юм.

Х.Ганхуяг: Б.Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Бид татвартай холбоотой хэсэг дээр нь хариулъя.

Тэр тоо бол яг зөв шүү. Д.Энхтүвшин гишүүн ээ.

Энэ чинь ийм юм байгаа юм. Хойтон 2 хувийг 5 болгохоор 3 хувийн зөрүү маань нийтдээ 1 их наяд болж байгаа юм. Одоо энэ чинь ер нь 400-аад тэрбум төгрөг. Энэ жилдээ. Хойтон энэ чинь бас дахиад 400-гаар гуравдугаар улирлынх нь нэмэгдэнэ. Дөрөвдүгээр улирлынх нь гүйцэтгэл чинь 2027 он руу шилжих учраас 2026 оны төсөв дээр байхгүй. Гүйцэтгэл нь тэгж гарна.

Тэгэхээр нийтдээ энэ чинь 1.2 их наяд гэж тооцоолох хэрэгтэй. Зөвхөн тэр 2 хувийг 3 хувь болгосноор.

■ Таны ярьж байгаа

- ▶ “ногдуулалт”,
- ▶ “аж ахуйн нэгжүүдийн агентын үүрэг гүйцэтгэх”,
- ▶ “мөнгөн суурьтай болгох”,
- ▶ “хил дээр авахгүй байх”^

Энэ өөрчлөлтүүдийг бид 2026 онд орж амжаагүй татварын багц өөрчлөлт дотроо оруулсан. Одоо бид **d-parliament** дээр тавиад саналуудаа аваад явж байгаа.

Ер нь өнгөрсөн бүтэн жил. Та ч гэсэн хэд хэдэн хэлэлцүүлэгт оролцсон. Таны хэлж байсан тэр саналууд ихэнх нь ер нь орсон байгаа.

Ингээд харин үүнийгээ **d-parliament** дээр хуулийн хугацаа нь... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тэгээд 11 сарын үеэр, 11 сарын 10-даар байх аа. Нөгөө хугацаа нь нээгдэнэ. Өргөн барих хугацаа нь. Тэр үед багц хуулиа өргөн барина.

Ингээд хэлэлцээд хавартаа батлах юм бол 2027 оноос үргэлжлээд татварын багц өөрчлөлтүүд явна гэж ойлгоорой. Тийм.

Бүгдийг нь зэрэг оруулахаар үнэхээр төсөв дийлэхгүй. Хойтон ямар байгаа билээ. Тийм байгаа шүү. Уучлаарай.

Х.Ганхуяг: Н.Учрал сайд аа, “Тавантолгой”-той холбоотой нэлээн том асуудал байгаад байдаг.

- Нэг ам нээнэ ээ гэдэг.

→ Яагаад нээх гэж байгаа юм. Хэлж мэдэх хүн байхгүй.

→ Ирэх жилийн төсөвт ямар нөлөөлөл үзүүлэх юм. Хэлж мэдэх хүн байхгүй.

Одоо ингээд сорчлоод цаашаа олборлож байгаа хэсэг нь ашиггүй болоод энэ хэсгийг нээх гээд байгаа юм уу гэдгийг хэлж мэдэх хүн байхгүй.

Уул уурхайн яам нь хүнээ ирүүлдэггүй. Энэ чинь өглөө 10-аас хойш залгаж байна шүү дээ. Нэг ч хүн ирдэггүй. Асуудлаа мэдэхгүй хүнийг хүн ирүүлээд сугалаад байдаг.

Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Түрүүн бид өөрсдийнхөө мэдлэгийн хүрээнд хариултаа өгсөн шүү.

Бид нүүрсээ экспортлох бидэнд 10 жилийн л хугацаа байна даа. 10 жилийн л хугацаа байна. Дэлхий нийтээрээ үүнээс татгалзаж байна. Урд манай зах зээл улам л хумигдаж байна. Тэр болтол бид түүхий нүүрсээ тултал экспортлох, тэр болтол бид дотооддоо энэ түүхий нүүрсээ тултал боловсруулдаг л болох хэрэгтэй байгаа.

Тийм учраас томоохон байгаа нөөцүүдээсээ хүрч чадаагүй байгаа хэсгүүдээ л эргэлтэд оруулъя, ашиглалтад оруулъя, уурхайн олборлолтоо хийж эхэлье, тээвэрлэе, экспортолъя гэдэг зорилт тавьж эхлүүлж байгаа ажлууд. Хөндөөгүй газруудаа. Хөндөөгүй байгаа газруудаа

Тийм учраас одоо энэ бол шууд төсөвт нөлөөгүй гэж бас үзэж болохгүй. Хэрвээ бид ирэх онд энэ тогтоолоо батлуулаад, ажлаа хийж чадах юм бол

Үндэсний баялгийн сан дээр тодорхой хэмжээний орлого нэмэгдэж... /минут дуусав/

Х.Ганхуяг: П.Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Ингээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам гээд нэг их тийм том сайдтай. Доод талын төрийн нарийн ч ирэхээ байлаа.

Нэг иймэрхүү л нөхцөл байдалтай өнөөдрийн ажил явж байгаа шүү дээ. Дандаа худлаа ярина. Ийм зүйл байна.

Би татварын даргаас асууя. 8, 9 сар дээр Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор ямар байдлаар зарагдсан хэчнээн сая тонн нүүрсэд ямар хэмжээний хөнгөлөлт өгөөд, ямар хэмжээний АМНАТ-ын орлого олсон бэ? Яг бодитоор хариулах ёстой шүү. Улсын Их Хуралд худлаа ярьж болохгүй.

Та доороос чинь мэдээлэл авах гэхээр бүгдийг нь миний гарын үсэгтэй өгнө гээд хязгаарласан юм билээ.

Тэгэхээр үүнийг Татварын дарга Ч.Чимидсүрэн. Тийм ээ. Дарга нэг хариулаадхаач. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би түрүүн Д.Пүрэвдаваа гишүүнийхтэй адилхан саналтай байгаа юм. Уг нь энэ төрийн өмчит компанийн засаглалын асуудлыг бараг Эдийн засаг, хөгжлийн яаманд өгмөөр байна.

Энэ төлөвлөлттэйгөө уялдуулаад

- ▶ альныг нь татан буулгах юм,
- ▶ альныг нь хувьчлах юм,
- ▶ альныг нь олон нийтийн болгох юм,
- ▶ альныг нь төр өөрөө авч үлдэж ашигт байдлыг нь нэмэгдүүлэх юм гэдэг юмаа төлөвлөмөөр байна шүү дээ.

Ерөөсөө уялдаа байхгүй. Тэгээд Эдийн засгийн яам нь нэг их төлөвлөх гээд. Чадахгүйдээ биш. Боломж нь угаасаа байхгүй ээ бид нарт.

Тэгээд дэлхий нийт чинь сая 2008-2016 оны хооронд 10-аад жилийн хугацаанд 260 биллион доллар өмч хувьчлал буюу олон нийтийн болгох хэсэг дээр явсан байна лээ шүү дээ. Төрийн өмчийг олон нийтийн болгох хэсэг дээр. Тэгээд тэрийг хамгийн их үр өгөөжийг нь хүртсэн манай Бүгд Найрамдах Хятад Ард Улс буюу урд хөрш маань байхгүй юу.

Бид хэд эндээс хоцорсон. Байгаа юмнуудаа өөрсдөө хийж байна гээд л хулгай зэлгээгээ л ихэсгэсэн.

Тэгэхээр уг нь үүнийг нэг төсвийн бодлоготой уялдуулаад, бас тодорхой хэсгүүдийг нь төсвийн орлого бүрдүүлэхэд ийм хэмжээний хяналтын багцыг нь биржээр арилжина, олон нийтийн болгоно гээд тодорхой тийм appetite хөдөлгөх. АЗЗА биш шүү. Ингэж дүр эсгэж хэдүүлээ төрийн өмчит компанийг олон нийтийн болгоё гэж худлаа хэлээд яах вэ.

Ийм байдлаар төсвийн бодлоготойгоо оруулаад ирсэн бол энэ уг нь зүгээр байсан юм. Ийм юм яригдаагүй юу? Б.Жавхлан сайд яг энэ асуудал дээр нэг хариулж өгөөч.

Б.Жавхлан сайд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа мэдэхгүй байна. Та тэр алба хаагчдыг загнаад яах вэ. Яг одоогийн хуулиар Б.Жавхлан сайд аа, танай яамнаас завсрын хэлэлцээр дээр 3 дүгнэлт гаргуулдаг байхгүй юу. 3 удаагийн дүгнэлт гаргуулдаг юм. Б.Жавхлан сайд аа. Тэр зөвшөөрөлтэй яг ялгаа байхгүй. Б.Жавхлан сайд аа.

Тэгэхээр энэ асуудал угаасаа танай яамнаас гарахгүй байгаа.

Тэгэхээр жоохон хөнгөвчлөөд эцсийн байдлаар төсвийн бодлоготойгоо уялдуулаад, үүнийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ, хэлэлцүүлэхгүй гэдэг байдлаар орж ирж байгаа төслийг би зарчмын хувьд дэмжиж байгаа шүү.

Хөөрхий хэдэн залуучуудыг тас тас загнаад явах юм. Энэ саадууд чинь байгаа шүү дээ. Бүхэл бүтэн.

Үүнийгээ бодитой засах гээд орж ирж байгаа зарчмын хувьд би ойлгож байгаа шүү. Тэгэхдээ харах юмнууд байна лээ. Н.Учрал сайд аа.

Х.Ганхуяг: Н.Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Тийм. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг төсөв дагуулж оруулж ирсэн.

Яагаад гэхээр жилийн төлөвлөгөөнд туссан 50 төсөл чинь санхүүжилт нь тодорхойгүй. Тэгээд сая

- Засгийн газрын **14 төслийг** эрэмбэллээ.
- Яам болгон дээр байсан **149 төслийг** эрэмбэллээ.
- ➔ 5 жилийн чиглэлийг маргааш Засгийн хуралд оруулах гэж байна. Их Хуралд өргөн мэдүүлнэ.
- ➔ 100 тэрбумаас дээш төслүүдээ хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нь багтаалаа.

Ингээд цэгцэлж байгаа. Засгийн газрын ажил хэвийн явж байгаа шүү.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг манай П.Сайнзориг надаас илүү мэдэж байгаа. Яагаад гэхээр тухайн үед Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар түншлэлийн хууль гаргасан гэсэн мөртлөө Сангийн яамнаас 3 удаа зөвшөөрөл авдаг байсан.

Эдийн засаг, хөгжлийн яам руу илгээгээд

- жагсаалтад оруулдаг,
- урьдчилсан шинжилгээ хийлгэдэг,
- бүрэн шинжилгээ хийлгэдэг.

Тэгээд тэр шинжилгээг нь хийлгэх гээд маш их цаг алддаг.

Тэгээд бүтэн KNOW-HOW-г нь, тэр нөгөө хувийн компанийн, нөгөө гаднын компанийн бүтэн KNOW-HOW-г нь жил гаруй ашиглагчаад хамгийн сүүлд нь сонгон шалгаруулалт зарладаг.

Тэгээд сонгон шалгаруулалт зарлангуутаа нөгөө жил гаруй ашиглагдсан компанидаа биш шал өөр, тэс өөр компанитай гэрээ байгуулдаг. Ингээд хүний “оюун санаа”, тэр “шинэ бүтээл”, тэр “бүтээгдэхүүний загвар”, “ашигтай загвар”-ыг ерөөсөө хайр гамгүй ашиглаж байгаа.

Тэгэхээр Монголд хэн итгэж хөрөнгө оруулаад түншлэлийн төсөл хэрэгжүүлэх юм бэ?

Тэгээд одоо энэ Эдийн засаг, хөгжлийн яам руу хандаад тэр баахан жагсаалтад оруулна гэнэ, зөвшөөрөл хүснэ гэнэ. Сангийн яам дээр 3 очно. Үгүй ээ, энэ чинь багадаа жил, 4, 5 сар юм билээ шүү дээ. Бараг 2 жил.

Ийм түншлэлийн төсөл гэж байхгүй. Харин П.Сайнзориг нийслэл дээр байхдаа тэр түншлэлийн хууль дээр нэг өөрчлөлт хийсэн юм билээ.

Засгийн газар хялбаршуулсан журмаар түншлэлийн төсөл хэрэгжүүлж болно гээд нэг журам баталсан юм байна. Тэр нь төсвөөс татаас авдаггүй аймаг, нийслэл гэдэг томьёолол оруулаад Засгийн газраас журам гаргаад нөгөө олон үе шатыг арай бууруулсан юм байна.

Тэгснээрээ нийслэл дээр чинь түншлэлийн төсөл харьцангуй явж байгаа байхгүй юу.

Аймгууд юу хүсдэг вэ гэхээр бид татаас авдаг нь үнэн. Гэхдээ гаднаас хөрөнгө оруулалт татаад энэ нэг зам барья гээд байна шүү дээ. Энэ нэг дэд бүтцийн төсөл хэрэгжүүлье гээд байна. Үүнийг хийх гэхээр төрийн захиргааны

төв байгууллагуудад чинь хандаад очихоор энэ их шат дараалал, энэ их хүнд суртлыг чинь дийлэхгүй юм байна гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр аймаг, орон нутаг болгон нутгийн өөрөө удирдах байгууллагаараа энэ түншлэлийнхээ төслийг “хялбаршуулсан журам”-аар шийд ээ.

- ▶ Нийтийн зориулалттай төрийн үйлчилгээний төсөлд ТЭЗҮ шаардахаа больё оо.
- ▶ Түншлэлийн төсөлд тавигдах “нийтлэг” болон “тусгай” шаардлагуудыг нэгтгэе ээ. Нэг шаардлагатай болгоё.

Дээрээс нь хугацаануудыг тавьж өгье.

- ▶ Хэдий хугацаанд тэр шинжилгээг хийх юм.
- ▶ Хэдий хугацаанд тэр үе шат нь яаж буурах юм

гэдэг хугацаануудыг нь тавьж өгөхгүй болохоор хугацаа тодорхойгүй яваад эхлэхээр болохгүй байна.

Тэгэхээр урьдчилсан болон уралдаант шалгаруулалтыг нэгтгээд нэг үе шаттай болгоод, оролцогчид тавигдах шаардлагаа давхцалгүй нэг болгоод, шаардлагагүй зарим шат дамжлагаа бууруулаад, хугацаагаа тодорхой болгоё гээд түншлэлийн энэ хуулийг оруулж ирсэн.

Тэгээд энэ төсөл дэмжигдсэнээр аймаг, орон нутгууд бүгдээрээ бие даагаад төслөө хэрэгжүүлээд явах, аймгийнхаа иргэдийн Хурлаараа асуудлаа оруулаад явах бололцоо нээгдэнэ гэж үзэж байгаа.

Х.Ганхуяг: Ч.Чимидсүрэн. 6. Номер уу?

Ч.Чимидсүрэн: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Татварын ерөнхий газар Ч.Чимидсүрэн.

АМНАТ-тай холбоотой 2025 онд бид 3.8 их наядыг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй яваа. Одоогоор 70 гаруй хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Түрүүн Засгийн газрын 55 дугаар тогтоолтой холбоотой асуудлаар бид Уул уурхайн яамтай тодруулга авахаар уулзалтууд, бичиг тоот шидэлцээд явж байгаа.

Өмнөх оныхоо АМНАТ, мөн тайлант оныхоо ногдлуудтай холбоотой авсан дүнгээ хэлье.

- ▶ 2025 оны 7 сар хүртэл 1.8 их наяд байна.
- ▶ 8 дугаар сард 435.0 тэрбум.
- ▶ 9 дүгээр сард 376.0 тэрбумыг бид төсвийн орлогод бүрдүүлээд байна.

Энэ яг ямар компаниуд биржээр хийгдсэн талаар дэлгэрэнгүй мэдээллийг бичгээр өгөхгүй бол яг одоо бэлэн биш байна.

Х.Ганхуяг: П.Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Төрийн өмчит компанийн асуудал дээр хэн ч хариулсангүй.

Ч.Чимидсүрэн, би чамд ажлыг чинь хийж өгье.

8, 9 сард 1.8 их наядын үнэлгээтэй биржийн бус замаар зарагдсан “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсийг чи жишээ нь хөнгөлөлт үзүүлээд, 163.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлээд төсөвт орох ёстой 15.2 тэрбум төгрөг ороогүй байгаа шүү.

- ▶ “Хангал эксплорэйшн” 2 тэрбумыг оруулаагүй байгаа шүү.
- ▶ “Жижиг Тавантолгой” 1 тэрбумыг оруулаагүй байгаа шүү.

Үүгээр чинь хөнгөлөлт эдлээд эхэлсэн. Чи яагаад худлаа яриад байгаа юм чи.

Хоёрдугаарт, Баялгийн сангийн энэ хэрэгжүүлэх журам чинь оффтейк гэрээ байгуулна гээд шийдсэн байна. Хар даа. Урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрнээр нь, цогцоор нь гэж байгаа.

Тэгээд энэ чинь Засгийн газар эргээд ямар хэлэлцээр хийгээд үр дүнгээ танилцуулахгүйгээр шууд эдийн засгийн эргэлтэд оруулах гээд оруулсан байгаа шүү.

Ийм ноцтой юм орж ирээд байхад ерөөсөө шал худлаа хариулаад яваад байх юм.

Хоёрдугаарт, Засгийн газарт үнэт цаас гаргах юун дээр чинь яагаад 1 тэрбум төгрөгийн, 1 тэрбум долларыг гаргана гэххээд өрийг... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулаад, дараа нь Н.Учрал сайд гүйцээгээд хариулчхаарай.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүн ээ, та Төрийн нарийн бичгийн дарга байхдаа уг нь аягүй хөөрхөн сайхан хууль ярьдаг байсан юм. Одоо энд орж ирснээс хойш жоохон хуулиас дээгүүр ярьдаг болсон байх юм. Аан.

Миний дүү наад хэмжээндээ яриарай.

Чи энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бид цуг боловсруулсан. Одоо хэрэгжиж байгааг нь. Энэ дотор бид Засгийн газар талдаа төсөв дээр аль болох эрсдэл багатайгаар, эрсдэлийг нь төсөв дээр авахгүй байхаар бүх хаалтуудыг нь хийсэн.

Яагаад гэвэл тэр үед бид концессын хууль гэдэг маш хар түүхтэй, маш их төсвийн эрсдэл дагуулсан ийм эрх зүйн орчныг арайхийж бөөн улс төр, хэд хэдэн Засгийн газрын аминд хүрч үүнийг зогсоож байсан. Тийм суурин дээрээс энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг цоо шинэ концепцоор, цоо шинэ үзэл баримтлалтайгаар төсөв дээр ямар нэг дарамт байхгүйгээр аль болох хувийн хэвшлийн төслийг төрөөс яаж дэмжих вэ гэдэг... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гэхдээ төсөв дээр эрсдэл байхгүйгээр хийсэн байдаг юм.

Тийм учраас одоо орж ирж байгаа үүнийг бид яах вэ арай чангаджээ. Буцаад арай зөөлрүүлье. Тэгж байж төсөв хумигдаж байгаа ийм үед төсөв дийлэхгүй хөрөнгө оруулалтуудаа хувийн хэвшлийн өөрсдөө хийе ээ гээд хүрээд ирж байгааг нь төсөв талаас нь дэмжээд, төр талаас нь дэмжих зүйлээрээ дэмжээд явъя гэдэг л ийм л үзэл баримтлалтай хууль байгаа юм шүү.

Өөр юу гэлээ? Тэр уул уурхайтай холбоотой. Тэр хардаа, ийм хараа. Спот арилжаа биш шүү. Ингээд шууд биржээр явуулах арилжааныг бөөн бөөнөөр нь хийх гэж байгаа юм шиг ойлгоод байх юм. Наадхаа сайн унш.

Огт хөндөөгүй байгаа, уулын ажлынх нь төлөвлөгөөнүүд нь батлагдсан, судлагдсан огт хөндөж чадахгүй байгаа тэр хэсгүүдээ эргэлтэд оруулъя гэдэг л заалт байгаа юм.

Таны яриад байгаа зүйл чинь эргэлтэд оруулснаас хойш хийгдэх зүйлүүд... /минут дуусав/

Х.Ганхуяг: Н.Учрал сайд гүйцээгээд хариулчих.

Н.Учрал: Төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах гээд хуулийг Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед өргөн барьсан шүү дээ.

Тэгээд Нийтийн өмчийн хууль Их Хурал дээр байна. Хуулиа гаргах хэрэгтэй. Концепцоороо л шийдье.

Энэ хоёр хууль гарахаар Засгийн газраас төрийн өмчит компани дээр баримтлах үндсэн чиглэл орж ирэх. Дагалдуулаад тэр нээлттэй болгох, нэгтгэх, нийлүүлэх асуудлыг нийлүүлж оруулж ирнэ.

Яагаад гэвэл Их Хурал өөрөө өмчийн эзэн. Тэгээд өмчийн эзнийг тодорхой болгохгүй бол эзэн нь хэн бэ гэдэг нь үл ойлгогдоод байна. Тийм учраас энэ хууль хүлээгдэж байна.

Засгийн газар өөрийнхөө хэмжээнд 20 орчим компанийг нэгтгээд, нийлүүлээд, өөрчлөн зохион байгуулаад явж байна шүү дээ. Явж байна. Тэгэхдээ одоо хууль орж ирж байж бодлоготойгоор тэр нээлттэй болгох асуудлыг нь шийдэхгүй бол хуульгүйгээр үүнийг ингэж явуулна гэж байхгүй болоод байгаа юм л даа.

Өмнө нь төсөв дагуулан оруулж ирдэг байсан. Бэлтгэл ажил хангагдаагүй учраас нээлттэй болоогүй олон компани байгаа.

Х.Ганхуяг: П.Сайнзоригийн микрофон өгье.

П.Сайнзориг: Би татвараас хариултаа авч чадсангүй.

Тэгэхээр би Б.Жавхлан сайдад зүгээр уншуулаад өгье өө. Та энэ Үндэсний баялгийн сангийн тухайн хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ 1.2 дахь заалтыг л харчхаарай. Жавхаа. Би сайд аа, худлаа яриагүй байхгүй юу.

Энэ ашиглагдаагүй ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг хэрэгжүүлэхдээ урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрнээр нь, цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэх, хамтрагч, хөрөнгө оруулагчид санал болгож хэлэлцээ хийх замаар эргэлтэд оруулах гээд Улсын Их Хурлаасаа шууд даваад эрхээ авлаа. Авах гээд байна та. Би үүнийг л сануулж хэлээд байгаа юм.

Үүнийг эргэлтэд оруулж төсвийн орлогоо бүрдүүлнэ, нэмье, баялгийн сангаа арвижуулъя гэдэг дээр бүгд тантай санал нэг байгаа.

Тэгэхдээ энэ томьёолол энэ тэр нь болж байгаа юм уу гэдэг зүйлийг л би танд хэлээд байгаа байхгүй юу. Үүнийг зарчмын хувьд бид ямар нөхцөлөөр гэрээ байгуулах гэж байгаа юм энэ тэр асуудлыг ярьж Улсын Их Хурал чинь шийднэ ээ дээ.

Тэгэхээр ийм зүйл байна шүү гэдэг зүйлийг хэлсэн.

Хоёрдугаарт, яагаад 1 тэрбум долларыг өрийн удирдлагыг зохицуулах, өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргаж байгаа юм бэ? Төсвийн орлогыг бас дутах... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Наад дотор чинь “борлуулах” гэдэг үг байна уу? Та дахиад нэг сайн дахин дахин сайн уншаарай. Орой бүр лааны гэрэл тавьж байгаад сайн уншаарай. Харахгүй байгаа бол. За юу.

Наадах чинь борлуулалт биш. Борлуулалт бол наадах чинь хуулиараа биржээр явах ёстой байгаа юм. Хуулиараа. Өөрийн чинь нөгөө яриад байгаа.

Та ч ер нь сүүлийн үеийн, ер нь сүүлийн 20 жилийн бүх хуулийг өөрөө бичсэн гэж яриад байгаа. Тэр олон бичсэн хууль дотор чинь наадах чинь маш тодорхой байгаа шүү.

Хоёрдугаарт, наад “өрийн удирдлага” гэдэг чинь чи бас арай сайн мэдэхгүй байгаа хэсэг чинь юм шиг байна.

Бид наад ер нэмж гаргах гэж байгаа асуудал биш. Одоо байгаа

- ➔ өрөө зохицуулах гэж байгаа,
- ➔ хямдруулах гэж байгаа,
- ➔ эрсдэлийг нь бууруулах гэж байгаа

ийм асуудал байдаг юм аа, миний дүү.

Х.Ганхуяг: Дууссан. Далайн Батбаяр гишүүн. 2 удаагийн тодруулга өгнө өө хөө.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд 2026 оны төсөвтөө дагуулж НӨАТ-ын тухай хууль болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль орж ирсэн. Хоёулаа маш чухал хууль байгаа. Бизнес эрхлэгчдэд болон худалдан авагч нар, иргэдэд шууд нөлөөлж байгаа хууль байгаа юм.

Тэгээд энэ дээр илүү их анхаарал хандуулмаар байгаа юм. Тэгээд энэ дээр ийм байна. Надад хоёр асуулт байна.

Яг энэ орж ирж байгаа хуулийн төслийн 15.2.1, 15.2.1.6 гээд яг энэ хоёр заалт дээр 2026 онд

- ▶ Сая хүртэл төгрөгийн худалдан авалт дээр НӨАТ-ынх нь **50 хувийг буцааж өгнө.**
- ▶ Саяас дээш байх юм бол **20 хувийг буцааж өгнө** гэж тусгасан байна.

15.2.1.6 дээр болохоор 2027 онд бүр 500 хүртэл мянган мянган төгрөгийн худалдан авалт дээр НӨАТ-аа **100 хувь буцааж өгнө** гэсэн төлөвлөлт гаргасан юм байна.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор асуулт байна. Яг энэ худалдан авалтуудыг бүртгэх бүртгэл маань ер нь судалгаа хийгдсэн байгаа юу? Хэдэн төгрөгийн, хэдэн удаагийн яг энэ 500 хүртэл, сая хүртэлх худалдан авалтууд хийгдэх вэ?

Үүнийг яаж бүртгэнэ гэж тооцоолж байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт байгаа.

Хоёрдугаар асуулт нь юу вэ гэхээр 2024 онд яг энэ нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллаар 346.0 тэрбум төгрөгийг 1.4 сая иргэдэд олгосон гэсэн мэдээлэл байна. Энэ үнэн үү гэдэг хоёрдугаар асуулт байна.

Гуравдугаар асуулт нь үүнээсээ гараад. Тэгвэл энэ шинэ хуулийн өөрчлөлтөөр 2025. 2025 ч яах вэ. 2026, 2027 онд иргэдэд очих урамшуулал нэмэгдэх үү, хасагдах уу? Бизнесийн байгууллагуудад ирэх дарамт дээр хийгдсэн судалгаа байна уу гэсэн ийм гурван асуулт байна.

Х.Ганхуяг: 1 номерт Б.Тэлмүүн хариулаарай.

Б.Тэлмүүн: Сангийн яам. Б.Тэлмүүн. Гишүүний асуултад хариулъя.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын урамшууллын хувьд би танд 2024 оны статистик хэлье.

Энэ статистик иргэдийн худалдан авалтын бүтэц ерөнхийдөө харагддаг. Энэ жил болгон хадгалагдаад, ерөнхийдөө яах вэ номинал дүнгээрээ өсөөд явдаг.

- 2024 онд нийт 1.4 сая иргэн урамшууллын буцаан олголтын хөнгөлөлт эдэлсэн байдаг.

▷ Эндээс нийт иргэдийн 25 хувь нь буюу 372 мянган иргэн нийт худалдан авалтын 75 хувь буюу 14.7 их наядын худалдан авалтыг хийсэн байдаг.

▷ Эсрэгээрээ нийт иргэдийн 1.1 сая буюу нийт иргэдийн 75 хувь нь нийт худалдан авалтын 25 хувь буюу 5.2 их наядын худалдан авалт хийсэн байдаг.

Ерөнхий худалдан авалтын бүтэц ийм байгаа.

Энэ дүн жил болгон тодорхой хэмжээнд эдийн засгийн өсөлттэй уялдаад өсдөг.

Худалдан авалтын хөнгөлөлтөөс хамаараад бид 1 сая төгрөг хүртэл 5 хувь болгож байгаа энэ хөнгөлөлт нийт иргэдийн 75 орчим хувь нь ирэх онд хамрагдаад явна.

2027 оноос 500 мянган төгрөг хүртэл худалдан авалт, НӨАТ-ыг бүрэн буцааж өгнө гэдэг. Энэ бол өөрөө нийт иргэдийн 51 хувь дээр хамрагдаад явна.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм НӨАТ-ын хуулийн шинэчлэл хэрэгжсэн тохиолдолд 500 мянга хүртэл сард **e-barimt**-ийн систем дээр худалдан авалт хийдэг иргэд нийт иргэдийн 51 орчим хувь байгаа нь НӨАТ-ын ачаалалгүй болно гэсэн ийм тооцоолол байгаа.

НӨАТ-ын буцаан олголтын дүн Та зөв хэллээ.

НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Засгийн газраас Legal Info цахим хуудсан дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу олон нийтийн хэлэлцүүлэгт тавьсан байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татвар бизнесийн орчинтой холбоотой хуулийн төслийг 60 хоног хэлэлцүүлэх хуультай. Энэ хуулийн дагуу компаниудын хувьд НӨАТ суутган төлөгч компани бизнес эрхлэгчдийн хувьд татварыг хэрхэн НӨАТ-ын хуулийн өөрчлөлт орох нь дэлгэрэнгүй танилцуулгууд зохицуулалтууд явна.

Өнөөдөр өргөн баригдсан хуулийн хүрээнд зөвхөн эцсийн хэрэглэгч иргэдтэй холбоотой зохицуулалт орсон байгаа.

Энэ дээр хэд хэдэн товч жишээ хэлэхэд НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд компаниудын хувьд НӨАТ хамгийн том асуудал болсон хэд хэдэн асуудлыг бид шийдвэрлэхээр зорьж байна.

► **Нэгдүгээрт**, НӨАТ бол өөрөө сар болгон төлөгддөг, тайлагнадаг татвар.

Тийм учраас хамгийн тулгамдсан асуудал бол мөнгөн хөрөнгийн асуудал байдаг.

Тэгэхээр мөнгөн хөрөнгийн хувьд бид татварын хууль тогтоомжийн үнэлгээ буюу SCORING SYSTEM⁴-ийг Татварын ерөнхий хуульд шинээр

⁴ Скорингийн систем нь тодорхой шалгуур үзүүлэлтүүдэд оноо буюу тоон үнэлгээ өгөх аргачлал юм.

- Судалгаа хийх;
- Мэдээлэл цуглуулах;
- Статистик болон математик загвар боловсруулах;
- Програмчлал, автоматжуулалт хийх;
- Туршилт, сайжруулалт хийх шаардлагатай.

нэвтрүүлээд, татварын хууль тогтоомжийг сайн мөрддөг, хариуцлагатай татвар төлөгчийн хувьд 1, 2 гээд 3 хүртэлх сараар НӨАТ-ыг хойшлуулан төлөх боломжийг олгохоор зохицуулалт байгаа.

► **Хоёрдугаарт**, импортын барааны хувьд лангуун дээр борлуулагдах хүртэл дунджаар Монголын компаниуд 2 сар орчмын дараа импортын бараа борлуулагддаг.

Тэгэхээр импортоор орж ирсэн барааны хувьд мөн 2 хүртэл сараар хойшлуулан төлөх ийм боломжуудыг олгоно.

Дээрээс нь үйлдвэрлэгч нарын хувьд НӨАТ хамгийн их санал өгдөг, хамгийн их гомдол мэдүүлж байгаа татвар байгаа. Яаж байна вэ гэхээр үйлдвэрлэгч нарын хувьд түүхий эдийг дотоодоос худалдаж авахдаа малчдаас байдаг юм уу, газар тариалан эрхлэгчдээс байдаг юм уу авахад e-barimt авна гэдэг нь өөрөө маш хүндрэлтэй байна.

Тэгэхээр e-barimt-гүй учраас, e-barimt хүндрэлтэй байгаа учраас хасалтаа хийж чадахгүй, НӨАТ-ын дарамт үйлдвэрлэгч нарын хувьд нэмэгдэж байна гэдэг нь судалгаагаар нотлогдсон байдаг.

Х.Ганхуяг: Д.Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Би уг нь аягүй тодорхой асуусан байхгүй юу.

Яг энэ бүх борлуулалтыг, бүх гүйлгээнүүдийг бүртгэх боломж байгаа юу? Энэ дээр технологийн боломж нь байгаа юу? Тэгээд маш олон төрлийн ангилсан гүйлгээнүүд хийгдэх юм байна. Тэр болгон дээр нь бизнесийн байгууллагууд дээр ч тэр, иргэд дээр ч тэр бас хүндрэл учрах юм байна. Тэгэхээр энэ бодитой юу гэдэг асуулт асуусан.

Хоёрдугаарт нь, ерөөсөө заавал ийм олон үе шаттай юм хийгээд байж байхаар ерөөсөө яг энэ бизнесийн байгууллагуудаа бодож байгаа бол. Сая та хариултдаа хэллээ шүү дээ. Ийм ийм учраас бараг 75, 85 хувь нь иргэд нь буцаан авалтад оролцдог гэж ярьсан.

Тэгэхээр яг энэ шинэ хууль хэрэгжиж эхэлснээр бизнесийн байгууллага дээр ирэх дарамт нь хэдэн хувь байх вэ? Ямар судалгаа байна вэ? Иргэд дээр ирэх татварын хөнгөлөлт маань өөрөө... /минут дуусав/

Х.Ганхуяг: 1 номер хариулъя. Тийм.

Б.Тэлмүүн: Сангийн яам. Б.Тэлмүүн. Гишүүний асуултад нэмж хариулъя.

Бидний татварын шинэчлэлийн туйлын зорилго бол яг тантай зорилго нэг.

НӨАТ-ын систем хамрагдалтын түвшнээр авч үзэх юм бол одоо бид эдийн засгийн 74 орчим хувь дээр хамруулж чадаж байгаа.

Бидний туйлын зорилго бол олон улсад хамгийн өндөр байдаг **Шинэ Зеланд 95 хувь** байдаг. Бид зүгээр 95 гэж мэдээж хэрэг амбицтай зорино.

Бидний туйлын зорилго бол 90 орчим хувь дээр хамрагдалтын түвшнийг аваачна.

Энэ шинэчлэлийг хийхэд Монгол Улс давуу олон талууд байна.

► **Нэгдүгээрт**, гар утасны системээ ашиглаад төлбөрийн баримтын системд иргэд маань татсан байна. Хуулийн шинэчлэлээр бид цахим төлбөрийн баримтыг автоматаар аль болох олгодог болно. Хэн нэгнээсээ нэхдэг, шаарддаг биш ер нь төлбөр хийгдсэн тохиолдолд автоматаар хийгддэг болно.

► **Хоёрдугаарт, e-barimt**-ын “нэхэмжлэх” гэдэг суурьтай систем рүү орно.

Тэгэхээр аж ахуйн нэгжүүд хоорондын гүйлгээ өөрөө автомат e-barimt-ын систем рүү шилжинэ.

Энэ шинэчлэлийг бид аль болох... /минут дуусав/

Х.Ганхуяг: Д.Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Энэ НӨАТ-ын тухай хууль хүчин төгөлдөр болсноор яг энэ НӨАТ-аас олох орлого маань ер нь хэдэн төгрөгөөр нэмэгдэх юм гэдгийг л хэлээд өгчих. 2026, 2027 онд.

Х.Ганхуяг: 1 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам. Б.Тэлмүүн. Нэмж хариулъя.

Яг өргөн барьсан хуулийн хүрээнд иргэдийн буцаан олголтыг үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа.

Энэ хүрээнд НӨАТ-ын орлого төсөвт хасах нөлөөтэй. Бид буцаан олголтыг нэмэгдүүлж байгаа учраас 375 орчим тэрбум төгрөгийн төсвийн орлогыг бууруулна.

Нөгөө талдаа бид тодорхой хэмжээнд татварын албан дээр хууль хүлээхгүйгээр хамрагдал нэмэгдүүлэх арга хэмжээг аваад бас 100 орчим тэрбум төгрөгөөр орлого нэмэгдүүлэх зорилтыг татварын байгууллагын түвшинд тавьсан байгаа.

НӨАТ-ын хууль иж бүрэн хэрэгжсэнээрээ бид дунд хугацаандаа НӨАТ-ын хамрагдалтыг 90 гаруй хувьд хүргэсэн тохиолдолд далд эдийн засаг болон НӨАТ-ын хамрагдалтын түвшнээр 1.7 их наяд орчим төгрөгийн нэмэлт орлогыг дайчлах, олох боломжтой ийм зорилт түвшин харагдаж байгаа. Бид энэ рүүгээ зориод ажиллана.

Тэгэхдээ энэ бол дунд хугацаанд олон шинэчлэлийн хуулийн заалтуудыг цогцоор нь хэрэгжүүлсний үр дүнд гарах асуудал байгаа юм. Баярлалаа.

Х.Ганхуяг: Би нэг л асуулт байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой.

Энэ хууль жоохон олон талаас нь юмнуудаа оруулж ирсэн болбол гэдэг байдал харагдаад байгаа юм. Яагаад гэхээр энэ чинь бас аягүй олон хэлбэртэй байдаг. Урсгал зардал дээр дарамт учруулахаар бол хязгаарлалт нь тавигдах ёстой л доо. Жишээлбэл урсгал зардлын тэдэн хувиас хэтэрч болохгүй гээд.

Бид ч яах вэ эндээ хэлэлцээд явна. Тэгээд л орон нутгийн төсөв бол бид үндсэндээ юу ч мэдэхгүй байж байгаад л тэр чигээрээ өнгөрөөд явна гэсэн үг.

Мөн дотаци авдаг аймгууд бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл, хөтөлбөрийг нь хэрэгжүүлээд явахаар эргээгээд сая Б.Жавхлан сайдын ярьдгаар нөгөө олон концесс шиг баахан юмнууд төсөв дээр нь ороод ирдэг.

Тэгээд Үндсэн хуулиараа бид тэнд ямар нэгэн байдлаар халдах эрх байхгүй гээд явдаг. Тэгээд нэг иймэрхүү асуудлууд байна л даа.

Тэгэхээр энэ дээр ер нь энэ Төр, хувийн шинэ түншлэлийн хуулиа оруулж ирэхдээ бас төсвийн хууль дээр тодорхой хэмжээний орон нутгийн төсөв дээр, улсын төсөв дээр хязгаарлалтын юмнуудаа оруулж ирэх ёстой байсан уу, үгүй юу гээд л асуултыг Н.Учрал сайдаас асуумаар байна.

Н.Учрал: Одоогийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр 4 билүү, 5 чиглэл байгаа.

Тэгээд 100 тэрбумаас доош төслүүдийг Засгийн газрын хялбаршуулсан журмаар улсын төсвөөс дотаци авдаггүй аймаг, нийслэл хийж болно гэдэг заалт байгаа юм.

Энэ заалтуудыг л бид аль ч аймагт яг энэ жишгийн дагуу хэрэгжүүлж болно гэдгийг нь нээсэн. Жишээ нь, нөгөө нийтийн үйлчилгээний, нийтийн үйлчилгээний зориулалттай дэд бүтцийн.

Одоо энэ дотор нөгөө хог шатаах үйлдвэр гэх мэт нэг ийм орон нутгийн нийгэм, эдийн засагт хэрэгтэй төслүүд байна шүү дээ. Үүнийгээ л орон нутгийн

түвшиндээ хийе гэдэг 5 төрлийнхөө төслүүд дээр л энэ боломжуудыг олгож байгаа юм.

Тэгэхээр заавал тийм алдагдалтай төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлээд байх шаардлагагүй.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр өөрчлөлт орсон тэр 5 төрөл, 100 тэрбумаас доош гэдэг заалтаа бариад, Засгийн газар журмаа оруулаад явсны үр дүнд нийслэл, зарим аймгууд түншлэлийн төслөө хэрэгжүүлээд яваад байгаа сайн жишээнүүд байгаа юм.

Тийм учраас аль ч аймаг яг энэ орон нутгийнхаа түвшинд хийж хэрэгжүүлж болох тэр нийтийн үйлчилгээний чиглэлийн төслүүдээ аймгийн хурлаараа оруулаад явуулж болно.

Харин түншлэлийн төсөл бүхэлдээ Сангийн яамнаас 3 дүгнэлт авна гэдэг чинь зөвшөөрөл шиг болоод байдаг. Түүнийг авахад маш их бэрхшээлтэй байдаг. Тэр болгоныг нь багасгаад олон ТЭЗҮ биш, нэг л шаардлага тавиад нийтийн үйлчилгээ дээр нь ТЭЗҮ заавал шаардахгүй болгоод ингээд бүхэлд нь шийдээд явбал эндээс тодорхой үр дүн гарна гэж зорьсон.

Хамгийн гол зүйл түншлэлийн төсөл чинь 13.2 дээрээ заасан байгаа. Одоо энэ эрчим хүч, дулаан хангамж, хог хаягдал, гадаргын ус, саарал усны барилга, байгууламж цэвэр, бохир усны шугам сүлжээ, хурдны зам, багтаамж ихтэй нийтийн тээвэр, хүнсний хангамж, аюулгүй байдлын хангахад чиглэсэн төслүүдийг орон нутгийн түвшинд хийж болно гэдэг өөрчлөлтийг хийж байна гэж ойлгож болно.

Хуучин түншлэлийн төсөл хэрэгжүүлэхийн тулд тэр шинжилгээнүүдийг хийлгэх гээд яам руу хандаад, яам нь түншлэлийн төвөөрөө дамжуулаад явдаг байсан.

Одоо бол “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”-д хандаад тэр шинжилгээгээ хийлгэх дээрээ хамтарч ажиллаад явах бололцоо нь шууд бүрдсэн гэсэн үг. Заавал яамаар дамжаад байх юм байхгүй. Тэр жагсаалт бичээд байх юм байхгүй.

Тэгэхээр аймаг, орон нутгийн түвшинд энэ түншлэлийн төвтэйгөө хамтраад тэр шинжилгээнүүдээ хийлгээд явна.

Ер нь энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр ч гэсэн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”-ийг төсвөөс санхүүждэг биш өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг ийм байгууллага байх ёстой гэдэг утгаар нь хуульчилж өгсөн. Төсвөөс санхүүжээд яваад байсан.

Одоо бид ерөөсөө л төсвөөс санхүүждэг биш тэр үйл ажиллагаагаар өөрийгөө санхүүжүүлээд явах бүрэн бололцоо эндээс бүрдэж байгаа юм.

Дээрээс нь түншлэлийн төслүүд дээр одоо жишээ нь шинжлэх ухааны салбар Эдийн засаг, хөгжлийн яаманд харьяалагдаж байна. Энэ хүрээлэнгүүд дээр маш олон бүтээгдэхүүний загвар, ашигтай загварууд байдаг.

Үүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах гэхээр одоо нөгөө R&D-г /RESEARCH & DEVELOPMENT/ хийхэд зардал мөнгө хэрэгтэй байгаад байдаг.

Тэгэхээр хэрвээ тэдгээр эрдэмтдийн бүтээсэн шинэ санааг эдийн засгийн эргэлтэд оруулбал түүнийхээ 5 хүртэлх хувийг нь ирэх жилийнхээ судалгаа хөгжүүлэлтэд зарцуулаад явах эрхүүдийг нь эндээс нээж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид байгаа оюуны өмчөө эргэлтэд оруулаад, тэр орон нутгийн түвшинд тэр хог боловсруулна уу, одоо тэр бусад... /минут дуусав/

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу? Б.Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Б.Түвшин.

Б.Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

Б.Мөнхсоёл: Энэ өргөн барьсан хуулиудын төсөвтэй холбогдох эсэх тал дээр хуульчид анализ хийсэн байна.

Тэгээд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.5 дугаар заалт гэж байгаа. Тэгээд түүнд гарсан дүгнэлт юу вэ гэхээр би бас зарим талаар санал нийлж байна. Юу вэ гэхээр яг төсөвтөө үзүүлэх нөлөөллийн судалгаа тун бага хийгдсэн буюу нөгөө зардал, үр ашгийн үнэлгээ бараг байхгүйтэй адил болсон байна гэсэн ийм дүгнэлтийг хуульчид гаргасан байна шүү.

Хоёрдугаарт нь, түрүүн асуух гэж байгаад больсон. Ер нь илэрхийллийн жоохон алдаа гарсан байх гэж бодсон. Өөрөөр хэлэх юм бол 2026 оны төсвийн орлого нэмэгдсэн өртгийн албан татвар дээр 286.0 тэрбум төгрөгөөр өснө гээд, ард талд нь НӨАТ-ынхаа холбогдох хуулийн нэмэлт, өөрчлөлт гээд түүндээ НӨАТ дээрээ болохоор 270 хэдэн тэрбум төгрөгөөр буурах нь гээд бичсэн.

Тэгэхээр өнгөц харж байгаа хүнд хоёр өөр дүгнэлт юм шиг. Бодвол НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт орсноор суурь татвар төлөгчдийн тоо нэмэгдээд, төлж байгаа буцаан олголт зарим хэрэглэгчид дээр буураад нийт дүнгээрээ л тухайн дүнгээр өсөх магадлалтай байсан нь буурч байгаа гэсэн санаа юм шиг байгаа юм. Гэх мэт энэ төсөв дээрээ илэрхийллийн байдлаас алдаа дутагдал байна шүү. Сайн анализ энэ тэрээ.

Түрүүний гишүүдийн хэлснийг давтаж хэлээд яах вэ. Илэрхийлэл, мэдээллийн бүрэн бүтэн гүйцэд байдал энэ тэр дээр анхаарах ёстой юм байна шүү л гэж хэлмээр байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Б.Түвшин гишүүн үг хэлье. Б.Түвшин гишүүний микрофон.

Б.Түвшин: Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар ганц хоёрхон санаа хэлье.

Нэмэгдсэн өртгийн албан татвар нэгдүгээрт яалт ч үгүй албан татвар шүү дээ. Татварын орлогыг бүрдүүлж байгаа татвар.

Хоёрдугаарт, бүртгэлийн зорилготой. Энэ бол тогтолцоо, системийг хамгаалж байгаа ийм л зүйл.

Гуравдугаарт, үнэ хөлс, өртгийг нь ялгаж өгч байгаа. Үнэ нэмэгдүүлж байгаа. Энэ гурван үйлчлэл эдийн засагт гардаг ийм л зүйл шүү дээ. Үүнийг бид нэг талаас нь яриад байж болохгүй байгаа юм.

Аж ахуйн нэгжүүд дээрээ ямар асуудал учруулж байна вэ гэхээр **“аккруал суурь, мөнгөн суурь”⁵**-ийн зөрүүнээс болоод эргэлтийн хөрөнгөгүй байж нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөх болдог. Энэ нь эргэлтийн хөрөнгийн дутагдалд оруулах, төлбөрийн чадварын эрсдэлд оруулах ийм эрсдэлтэй байдаг.

Тэгэхээр нэмэгдсэн өртгийг аж ахуйн нэгжүүд дээр хэнээс аваад байна вэ гэхээр бараа дамжуулагчаасаа худалдаж аваад тэрийгээ суутгаад, яг өөр дээр нь нэмэгдэж байгаа өртөг буюу ихэвчлэн хөдөлмөрийн хөлстэй адилтгах хэмжээний тэр зүйл дээрээс нь нэмэгдэж өртөг болоод, буцаагаад иргэд дээр энэ чинь үнийн өсөлтийг нэмэгдүүлж байгаа.

Ерөөсөө татварын орлогыг буцаагаад иргэд буюу ялангуяа тодорхой орлого багатай иргэдэд буцааж өгье гэдэг чинь татварын орлого буюу төсөвт цуглуулах, төсвийн орлогыг, төсвийн тодорхой орлогын бүрдэл хэсгийг, нөгөө талдаа төсвийн бүртгэл, хяналтын тогтолцооны нэг хэсэг болж байгаа энэ зүйлийг буцаагаад иргэдийг төртэй хамааралтай болгох тогтолцоогоо улам хольж хутгах, халамжийг нь ч гэдэг ч юм уу, эсвэл ахуй амьдралыг нь тэтгэдэг ч юм уу, орлогыг нь нэмэгдүүлэх болгох. Гэхдээ үнэ өртөг нэмэгдсэний дараа буцаан олголт явж байгаа нь нөлөө багатай гэж би хувьдаа үзэж байна.

⁵ Аккруал суурь: Орлого, зардлыг үүссэн үед нь мөнгө орж, гарахаас үл хамааран бүртгэнэ.

Мөнгөн суурь: Орлого, зарлагыг мөнгө орж ирсэн буюу гарсан үед бүртгэнэ.

Зөрүү нь: Аккруал суурь нь эдийн засгийн бодит байдлыг илүү үнэн зөв харуулдаг бол мөнгөн суурь нь зөвхөн мөнгөн урсгалыг харуулдаг.

Тийм учраас нэмэгдсэн өртгийн албан татварыг тэр буцааж олгох гэхээсээ илүү тодорхой хувиар бууруулах нь энгийн бөгөөд цэгцтэй, татвар ойлгомжтой, товч бөгөөд тодорхой байлгах ёстой гэж үзэж байгаа.

Бүх зүйлийг нэмэгдсэн өртгийн албан татвартай болгоё гэж байгаа нь бүртгэлийн зорилгоор байж магадгүй. Тэгвэл “тэг” хувийн татвар гэж бас байгаа. Ингэж байж бүртгэлийн системээ хийнэ үү гэхээс биш.

Одоо ялангуяа хөдөлмөрийн хөлс дээр нэмэгдсэн өртгийн албан татвар нэмдэг. Үнэ бол зах зээл дээрээ тогтож байгаа тохиолдолд бараа, материалын үнэ өсөх хандлагатай. Эсвэл оюуны хөдөлмөр эрхэлдэг төрлийн бизнесүүдийн ашиг, алдагдал буурах, төрийн үйлчилгээнүүд буцаагаад өөрөө үнэ хөлс нь нэмэгдэх ийм эрсдэлтэй байгааг анхаарч энэ дээр бодож үзээрэй гэдгийг энэ үгээр хэлэх гэсэн юм.

Х.Ганхуяг: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье. Санал хураалтад бэлдээрэй гишүүд ээ.

Өнгөрсөн долоо хоногийн 4 дэх өдрийн чуулганаар төсөв орох байсан боловч Засгийн газрын асуудалтай холбоотойгоор хойшилсон.

Тэгээд бид өнөөдөр цаглавараараа Байнгын хороон дээрээ төсөв дагасан хуулиудыг хэлэлцэх цаглавартай байсан. Тэгээд энэ дөрөв дэх, тав дахь өдрийн чуулганаар төсөв хэлэлцэх эсэх санал хураалт явагдана.

Хэрэвзээ хэлэлцэхгүй ээ, буцаана гэх юм бол энэ угаасаа хамтдаа л буцна.

Тэгэхээр бид Байнгын хороон дээрээ дахиад долоо хоног алдаж байхаар өнөөдөр бас ингээд санал хураалт явуулаад, юмаа бэлэн болгож байсан нь зөв байх аа гэж харж байна.

Ц.Даваасүрэн дарга зөвшөөрч байгаа болохоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Х.Булгантуяа гишүүн ороогүй байна шүү. Х.Булгантуяа гишүүн ороогүй байна. З.Мэндсайхан гишүүн байна уу? Д.Пүрэвдаваа гишүүн ороогүй байна. Б.Чойжилсүрэн сайд ороогүй байна. Д.Үүрийнтуяа байхгүй байна. Тийм ээ. Орсон байна.

Саналаа хураая. /алх цохив/

19 гишүүнээс 14 гишүүн буюу 73.7 хувиар дэмжсэн байна.

2.Төр, хувийн шинэ түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

Т.Аубакир гишүүн суугаарай.

19 гишүүнээс 14 гишүүн дэмжиж санал өгсөн байна. 73.7 хувиар дэмжигдсэн байна.

3.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүнээс 14 гишүүн дэмжсэн байна. 73.7 хувиар дэмжигдсэн байна.

4.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүнээс 13 гишүүн дэмжсэн байна. 68.4 хувиар дэмжигдсэн байна.

Санал хураалт явуулж дууслаа.

Дээрх 2 хууль, 2 тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн дээрх хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулж дууслаа. /алх цохив/

Гурав дахь асуудалдаа оръё.

**Хоёр.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос
Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар
Монгол Улсын Ерөнхий аудиторт хандсан
асуултын хариуг хэлэлцэх**

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Монгол Улсын Ерөнхий аудиторт Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар тавьсан асуултын хариуг хэлэлцэж эхэллээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Тамгын газрын Тэргүүлэх аудитор, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудиторовын газрын захирал, Тэргүүлэх аудитор.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114.1.1-д Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байна гэж заасан.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын асуултын хариуг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулна. С.Магнайсүрэн даргын микрофоныг өгье. 5 номер.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар 33 дугаартай асуултыг Монгол Улсын Ерөнхий аудиторт ирүүлсний дагуу 2025 оны 9 сарын 10-ны өдөр хуулийн дагуу хариуг хүргүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуултын дагуу дараах хариулт, мэдээллийг Та бүхэнд товчлон танилцуулж байна.

Үндэсний аудитын газар 1996 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагуудад гишүүнчлэл бүхий дэлхийн 196 орныг эгнээндээ нэгтгэсэн “Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага” INTOSAI /International Organization of Supreme Audit Institutions/, 48 орны гишүүнчлэлтэй “Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага” ASOSAI /Asian Organization of Supreme Audit Institutions/-д бүрэн эрхт гишүүнээр элссэн.

Тус байгууллагууд нь Аудитын дээд байгууллагуудын хараат бус байдлын тухай Лима /Lima Declaration, 1977/-гийн болон Мексик /Mexico Declaration, 2007/-ийн тунхаглалыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах үүргийг хүлээдэг.

Эдгээр тунхаглалуудын гол зорилго нь хараат бус төрийн аудитыг бэхжүүлэх, бүрдүүлэх, энэ шаардлагыг хангахгүй аудитын дээд байгууллага стандартад үл нийцнэ гэж үздэг бөгөөд аудитын дээд байгууллага зөвхөн хараат бус байдлыг олж авснаар биелэгдэхгүй. Энэ хараат бус байдал нь дотоодын хууль тогтоомжоор баталгаажсан байхыг шаарддаг.

Хөндлөнгийн буюу түншийн үнэлгээг аудитын дээд байгууллагууд хийлгэж, үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр ажилладаг.

Энэ хүрээнд

- ▶ 2010 онд Норвег Улсын Ерөнхий аудиторын газрын дэмжлэгтэйгээр Швед Улсын Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудитын тогтолцоо болон үйл ажиллагаанд,
- ▶ 2016 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Үндэсний Аудитын газраас санхүүгийн аудитын үйл ажиллагаанд тус тус хөндлөнгийн буюу түншийн үнэлгээ хийгдсэн.

Эдгээр үнэлгээгээр Төрийн аудитын тухай хуульд санхүүгийн болон байгууллагын хараат бус байдлын талаар тодорхой хэмжээний зохицуулалт байгаа ч Үндсэн хуулийн зохицуулалтгүй байгаа нь хараат бус байдалд нөлөөлөх эрсдэлтэй гэж манайхыг дүгнэж байсан.

Төрийн аудитын байгууллага Лимагийн болон Мексикийн тунхаглал түншийн үнэлгээгээр өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын талаарх зохицуулалтыг тусгуулахаар Улсын Их Хуралд хүсэлтийг уламжилж байсан бөгөөд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орж, төрийн санхүү, төсвийн хяналтын хараат бус хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж хуульчлан баталсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл баримтлал, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийг шинэчлэн найруулж батлан гаргасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага гэж тусгайлан тусгаж өгсөн.

Төрийн аудитын үндсэн зорилт нь:

- Санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр
 - ▶ төлөвлөх,
 - ▶ хуваарилах,
 - ▶ ашиглах,

➤ зарцуулахад хяналт тавих.

Түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг.

Энэхүү зорилтын хүрээнд төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэн өнөөгийн байдлаар төрийн аудитын байгууллага улсын хэмжээнд

- ➔ санхүүгийн тайлангийн аудитад 6800 орчим байгууллагыг,
- ➔ гүйцэтгэл нийцлийн аудитад 7100 гаруй байгууллагыг хамруулан аудит хийж байна.

Олон улсын Люмагийн тунхаглалд “Аудитын дээд байгууллага жилд ажил үүргээ хэрэгжүүлэх боломж олгохуйц санхүүгийн хөрөнгөөр хангагдана.” гэж заасан бол Төрийн аудитын тухай хуулийн 40.1-д “төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ.”, “аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана.”, “Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Их хурлын Төсвийн байнгын хороонд хянуулахаар хүргүүлнэ.”, “Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хянагдсан Төрийн аудитын байгууллагын төсвийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”, “Засгийн газар төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус Төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг хуульчлан зохицуулсан.

Гэвч бодит байдал дээр хэрэгжихгүй, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аудитын байгууллагын жилийн төсвийн хязгаарын саналыг хянаж, тодорхой хэмжээгээр бууруулан Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулсаар өнөөдрийг хүрсэн.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Үндэсний аудитын газарт хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Австралийн Үндэсний аудитын газар болон Индонез Улсын аудитын зөвлөл хамтран 2023 онд түншийн үнэлгээний тайланд сүүлийн жилүүдэд Сангийн яам төрийн аудитын байгууллагын төсвийг улсын төсөвт нэгтгэхдээ бууруулсан. Тухайлбал, Төсвийн байнгын хорооноос хянагдсан төсвийн дүнгээс

- 2020 онд 1.4,
- 2021 онд 2 тэрбум,
- 2022 онд 1.1,
- 2023 онд 2.6 тэрбум төгрөгөөр бууруулж санхүүжилтийг Улсын Их Хурлаас баталсан байна.

Дээрх... /минут дуусав/

Х.Ганхуяг: Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүн байна уу?

Дэгийн тухай хуулийн 114.1.2-т холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттай холбоотой өөр асуулт асуух гэж заасны дагуу асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд асуулт асууна.

С.Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Г.Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүнээс тавьсан асуулгатай холбогдуулаад бид энд онцгой анхаарахаар, нягталж үзэхээр, дараагийн Байнгын хороодын хуралдаан дээр ч гэсэн тайлангуудыг сонсохоор асуудлууд байна гэж харж байгаа.

Нэгдүгээрт, Төсвийн байнгын хороо Үндэсний аудитын газраас хийсэн өрийн удирдлагын стратегийн дунд хугацаанд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн явц 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хийсэн байна.

Тэгэхээр би ойрын хугацаанд холбогдох Байнгын хороонд буюу Төсвийн байнгын хороонд Засгийн газрын өрийн удирдлагатай холбоотой асуудлыг танилцуулаач ээ гэдэг асуудлыг тавих гээд байгаа юм.

Энэ бол манай Байнгын хорооны гишүүд өрийн удирдлагатай холбоотой, эрсдэлтэй холбоотой асуудлууд дээр онцгой анхаарах шаардлага байна гэж харж байгаа.

Би эндээс онцлоод хэлэх гээд байгаа асуудал маань нэг талдаа бид яг Та бүхний гаргасан энэ өрийн удирдлагатай холбоотойгоор, гадаад зээл, тусламжийн хяналтгүй байгаа энэ асуудалтай холбоотойгоор тавьсан дүгнэлт түүдтэй 100 хувь санал, дүгнэлт нийлж байна.

Энэ дээр нэг талдаа бид гадаад өрийн удирдлагыг сайжруулах зайлшгүй шаардлага байна гэж хараад байгаа.

Тэгэхээр бид өрийн үлдэгдэл, гадаад зээлийн өрийн үлдэгдэл өөрөө их нэмэгдэж байна. Тэр дундаа ирэх 2026 оны төсвөөр нэрлэсэн үнээр 51.2 их наяд хүрэх гээд байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний маань 43.8 хувьд үндсэндээ гадаад зээл, тусламж буюу өрийн үлдэгдэл бий болж гарч ирж байна.

Тэгэхээр энэ бол нэг талдаа бид зайлшгүй анхаарах ёстой, энэ дээр тодорхой хэмжээний хязгаарлалтуудыг хийх ёстой асуудал байна. Дунд хугацаандаа төсөв, санхүү дээр эрсдэл учруулах асуудлууд байна. Улс орон

өөрөө энэ эрсдэлтэй зүйл дээр бас тодорхой анхаарал хандуулж гарахгүй болохгүй байна.

Зөвхөн өрөөс гадна бонд, өрийн баталгааны асуудлууд жил бүр нэмэгдэж байгаа асуудал байгаа.

Та бүхний дүгнэлт дээр бас энэ гарсан байна. Энэ өөрөө бид зайлшгүй анхаарах ёстой асуудал. Би зөвхөн 2026 онтой холбогдуулаад хэлэх юм бол гадаад зээл, бондод 3.7 их наяд төгрөг буюу ийм өрийн үйлчилгээ, хүүгийн зардлыг бид төлөх нь. Өрийн үйлчилгээ, хүүгийн зардлыг төлөх нь. 3.7 их наяд.

Үндсэндээ 365 хоногтоо хуваагаад үзэх юм бол бараг өдөрт Монгол Улс 10.1 тэрбум төгрөгийг төлж байна гэсэн үг болж байгаа. Өдөрт бид 3 цэцэрлэг өрийн үйлчилгээндээ төлж байна гэсэн үг болж байгаа юм. Гадаад өр болон бондтой холбоотой, үнэт цаастай холбоотой энэ өрийн үйлчилгээний зардлууд.

Тэгэхээр энэ дээр би Та бүхний гаргасан дүгнэлтүүдтэй бүрэн дүүрэн санал нийлж байгаа. Байнгын хороо болоод холбогдох Байнгын хороо бид энэ асуудлыг онцгойлон авч үзэж, цаашид дунд хугацаанд төсөв, санхүү дээрээ ямар нэг эрсдэл байлгахгүйгээр анхаарах зайлшгүй шаардлага байна.

Мөн дээр нь үүнтэй холбоотойгоор орон нутгууд, аймгууд үнэт цаас гаргадаг. Мөн дотоод зээллэг болоод гадаад зээлийн хэмжээг нэмэгдүүлж байгаа асуудлуудыг хязгаарлах зайлшгүй шаардлага... /минут дуусав/

Х.Ганхуяг: Үг хэлсэн үү? Аан. 5 номер. С.Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг өнгөрсөн оны 12 сард Төсвийн байнгын хороо баталж өгсөн. Энд

- хуулийн дагуу хийгдэх 17,
- бодлогоор хийгдэх 24.

Ингээд нийтдээ 41 сэдвээр манай аудитын байгууллага 2025 онд аудитыг хийж гүйцэтгэж байгаа.

Энэ хүрээнд бид Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн сэдвээр 2021 онд хийсэн байдаг юм билээ.

Өнөөдөр хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж сэдэвтэй гүйцэтгэлийн аудитыг 2023 онд бас хийсэн байгаа.

Мөн өрийн удирдлагын стратегийн дунд хугацаанд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн явцыг 2023-2024 оны байдлаар гаргасан ийм гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэсэн.

Ингээд эндээс харахад бид 7, 8 нийтлэг алдаанууд, зөрчлүүд байнга давтагдаад байна гээд С.Эрдэнэболд гишүүний асуулт дээр нэлээн тодорхой хэлсэн. Цаашид анхаарах асуудлуудаа бас хэлсэн байж байгаа.

Тэгээд гүйцэтгэлийн аудитын сэдвийг Байнгын хороогоор ярих үед бид дэлгэрэнгүй энэ тал дээр мэдээлэл гишүүдэд өгөх бололцоо байгаа.

Гаднын зээл, тусламжийн ашиглалттай холбоотой асуудлыг анхаарах нийтлэг тийм зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа.

Х.Ганхуяг: С.Эрдэнэболд гишүүн дэгийн тухай хуулийн 114.1.2-т холбогдох албан тушаалтанд асуулт хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттай холбоотой өөр асуулт асуух гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд асуулт асууна.

Тодруулах юм уу? Тодруулъя. Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Бид өнгөрсөн онд 2025 оны төсвийг 2024 оны 12 сарын 12-нд баталсан.

12 сарын 12-нд бид батлахдаа Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолыг баталсан байгаа.

Энэ тогтоолоор аудитын байгууллагад буюу Засгийн газарт нэг үүрэг даалгавар өгсөн юм. Аудитын байгууллага болоод Засгийн газар хоёрт. Энэ юу вэ гэхээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтээр үнэлэлт дүгнэлт хийгээч ээ. Тусгай сан бүрийнх нь зориулалтаар нь төсөвлөлт, зарцуулалт болгон дээр нь гүйцэтгэлийн аудит хийгээч ээ гэдэг асуудлыг тавьсан.

Энэ бол бид бүхэн өнгөрсөн жил төсөв дээр ажилласан ажлын хэсгийнхнээс гаргасан санал байгаа юм. Тусгай сангийн энэ сан тус бүрийнх нь зориулалтууд нь, төсөвлөлтүүд нь, зарцуулалтууд нь үр ашиггүй байна гэдэг асуудлыг бид хөндөж гаргаж тавьсан. Энэ дээр тодорхой хяналтыг хийх ёстой байна гэдэг асуудлыг тавьсан.

2025 оны хаврын чуулганы хугацаанд өргөн мэдүүлье гэдэг үүрэг даалгаврыг Засгийн газар аудитад өгсөн. Энэ ямар гүйцэтгэлтэй байна?

Х.Ганхуяг: 5 номер.

С.Магнайсүрэн: Асуултад тодруулж хариулъя.

Засгийн газрын тусгай сангуудаар. Одоо жишээлбэл санхүүгийн тайлан жил болгон хуулиар ордог. Бүх байгууллагуудад. Энэ хүрээнд бүх тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж байгаа. Яг үйл ажиллагаа, гүйцэтгэл, нийцэлтэй нь холбоотой асуудлаар бид жишээлбэл боловсролын зээлийн сангийн аудит хийгдээд дууссан. Шалгагдагч байгууллагаас хамгийн сүүлийн тайлбар саналаа ирүүлсэн. Одоо бид өнөө маргаашгүй Байнгын хороонд оруулж ирнэ.

Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн асуудал. Тийм ээ. Энэ сэдвээр Хөдөө аж ахуйн яамны дэргэдэх хэд хэдэн сангуудын асуудлаар бид орсон. Энэ 10 сардаа багтааж тайлангаа өгнө.

Ер нь сангуудын юуг төлөвлөснийхөө дагуу хийж байгаа. Төсвийн байнгын хорооны... /минут дуусав/

Х.Ганхуяг: 5 номер гүйцээгээд хариулъя.

С.Магнайсүрэн: Төсвийн байнгын хорооноос баталж өгсөн сэдвийн хүрээнд бид энэ ондоо багтаагаад холбогдох орж ирэх ёстой зээлийн сан, ахмадын сан, бусад Боловсролын зээлийн сан, Хөдөө аж ахуйн яамны харьяа бүх сангуудын юмыг үзэж байгаа учраас энэ ондоо багтаагаад бид хугацаандаа өгнө.

Зүгээр зарим нэг сэдвийг бид он дамнуулж хийх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа. Үүнийгээ бид сэдэв батлахдаа цуг оруулж ирээд Байнгын хорооныхоо гишүүдтэй ярилцаж саналыг нь авна гэсэн тооцоо хийж байгаа.

Ер нь хугацаандаа хийгээд өгнө. Хаврын чуулганд амжихааргүй ажил байсан.

Х.Ганхуяг: С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Асуулт, үг нь нийлээд 5 минут байгаа учраас би эхлээд агуулга яриад дараа нь асуултууд асууя.

2025 оны 5 сарын 08-ны өдөр Та Улсын Их Хурлаар томилогдсон. 5 сар 6 хоногийн өмнө.

Таныг томилогдоход тодорхой зүйлүүдийг хэлж байсан. Үүнээс хойш 5 сар өнгөрчээ. Яасан бэ гэхээр бид нарын хамгийн гол төсвийн үеэр өрнөдөг маргаан бол төсвийн эрэмбэ хийгээд, тэр төсвийг ач холбогдлоор нь зорилтод хэрэгжих тэр боломжтой нөхцөлөөр нь бид яаж ялгах юм бэ гэдэг асуулт гол маргааны сэдэв болоод байгаа юм л даа.

Жишээлбэл, Та бүхэн санаж байгаа байх. 7 сард гишүүдэд мөнгө тараах гэж байна. Тойргийн гишүүдэд тийм, жагсаалтын гишүүдэд тийм гээд л яриа болдог. Иргэд, олон нийтийг бухимдуулдаг.

Гэтэл энэ улс орон чинь нэг бүхэллэг эдийн засгийн анатоми, эдийн засгийн цусны урсгалтай гэж үзэх юм бол тэр дотор нь бас энэ цагаан эсийн үүргийг буюу дархлааны үүргийг аудитын байгууллага хяналтаараа гаргаж байх ёстой.

Гэнгүүт Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд энэ төсөв нийцэж байгаа эсэх дээр аудитаас дүгнэлт өгөхөөр ерөнхий дүгнэлтдээ нийцэж байна гэж гардаг ч гэсэн яг детальчилсан буюу нарийвчилсан дүгнэлт эрэмбийн асуудал дээр танайх дүгнэлт өгч чадахгүй байгаа. Үүнийг хийхийн тулд ямар эрх зүйн зохицуулалт хэрэгтэй вэ гэдэг талаар С.Магнайсүрэн дарга бид хэд удаа дараа ярьсан. Гурав, дөрвөн удаа энэ асуудлаар ярьсан.

Тэгэхээр Их Хурлын гишүүний 8 сарын 26-нд илгээсэн асуулт бол үүнийг шийдвэрлэхэд бас чиглэж байгаа юм.

Бид энэ аудитын байгууллагын тайлан тооцоо, хяналтыг бие даасан, хараат бус байдлаар илүү үр өгөөжтэй, олон улсын стандартад явуулах тусам манай улсын төсөв тодорхой, төсвийн эрэмбэ ойлгомжтой, түүний хэрэгжилт нийгэмд үзүүлэх үр нөлөө, тэр хөрөнгө оруулалтаар илэрч байгаа бүх зохицуулалт нь ил тод болох гээд байгаа юм.

Тэгэхээр чөтгөрүүд детальд байдаг гэдэг шиг яг ийм зүйл болоод байгаа юм.

Тэгэхээр гол асуудал болохоор илгээсэн асуултын дагуу С.Магнайсүрэн даргын байгууллагаас нийтдээ 11 хуудас материал ирүүлсэн байгаа.

Сая танилцуулгын цаг товчхон учраас энэ бүхнийг ярьж амжаагүй.

- **Нэгдүгээрт**, та энэ асуултуудад маш товчхон хугацаандаа багтаад хариулаач ээ гэж байгаа юм. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдал гэж байгаа.

Маш товчхон энэ дээрээ Улсын Их Хуралд Та танилцуулга хийж байгаа учраас, Байнгын хороонд танилцуулга хийж байгаа учраас яг энэ асуудал дээрээ та хамгийн чухал зүйлүүдээ хэлээч ээ гэж байгаа юм. Тэгэх юм бол Их Хурлаас, Байнгын хорооноос ч гэдэг юм уу, энэ дээр бас анхаарал хандуулаад энэ орчныг боловсронгуй болгох, илүү тодорхой болгоход бид алхам хиймээр байгаа юм. Нэг.

- **Хоёрдугаарт**, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хараат бус хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааны талаар гэж

байгаа. Энэ дээрээ бас хамгийн чухлыг нь хэлээч ээ. Сая ийшээгээ танилцуулга чинь орж чадаагүй. Дууссан.

- ▶ **Гуравдугаарт**, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн улсын жилийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт саналыг өгөөд байдаг. Үүний хэрэгжилт нь учир зүйн хувьд үр дагаврын талаар Та танилцуулга ирүүлсэн байгаа. Яг эндээ жишээлбэл яг юун дээр бид энэ хэрэгжилт дээрээ алдаад байна.

Өөрөөр хэлбэл олон улсад хэллэгээр IMPLEMENTATION буюу хэрэгжүүлэлт дээрээ бид алдаад байгаа шүү дээ.

Энэ дээр та нэг маш товчхон хариулт өгмөөр байна. Яагаад гэхээр цаг бага байгаа учраас товч товч хариулт өгөөд.

Дараа нь болохоор улсын нэгдсэн төсөв дэх хөрөнгө оруулалтын төсөлд. Одоо энэ гол юм чинь орж ирж байгаа.

- ▶ Төсөл,
- ▶ хөтөлбөр,
- ▶ арга хэмжээ,
- ▶ худалдан авах ажиллагаа,
- ▶ гадаадын зээл, тусламж.

▶ Хандив, санхүүгийн дэмжлэгийн

- ▶ төлөвлөлт,
- ▶ гүйцэтгэл,
- ▶ ашиглалт,
- ▶ зарцуулалт,
- ▶ хэрэгжилт,
- ▶ тайлагнал дахь гол алдаа гэж байгаа.

Энэ дээр хамгийн чухал зүйлүүдээ Та Байнгын хорооны хурал дээр хэлмээр байгаа. Энэ дээр чинь улс төрийн гол маргаан болдог. Энэ дээр чинь улс төр тогтворгүй байх гол юм болоод байна шүү дээ.

Үндсэндээ одоогийн Монгол төрд нүүрлээд байгаа хямралын гол зангилаа асуудал чинь энэ дээр яваад байна шүү дээ. Жишээлбэл, нүүрсээр илэрч байна.

Эдгээрийг тэгвэл яаж дахин давтахгүй байх эрх зүйн орчин тал дээр Та мэргэжлийн байгууллага удирдаж байгаа хүний хувьд танай байгууллагын дүгнэлтээс хамгийн гол санаануудаа л хэлмээр байгаа юм.

Тэгээд Байнгын хорооны даргаас хүсэхэд энэ аягүй чухал асуудал байна. Түрүүн Г.Тэмүүлэн гишүүн ч гэсэн онцолж хэлж байгаа асуудал. Өрийн удирдлагатай холбоотой асуудал. Үүнийг Улсын Их Хурлын гишүүддээ түгээж өгмөөр байгаа юм. Үүнийг мэдээлжүүлмээр байгаа юм.

Аудитын байгууллагаас нэг зүйлийг нэмээд хүсэхэд Та бүхэн энэ дээрээ жоохон ажилсаг байдлаар хандаад ийм презентаци хэлбэрээр хийгээд маш богино хугацаанд товч ойлголт, гол агуулгуудыг ойлгох түвшинд хялбарчилсан мэдээллийг дэлгэрэнгүй мэдээлэлтэйгээ хамт Байнгын хороонд өгөх юм бол үүнийг бас гишүүдэд уншуулмаар байгаа юм.

Энэ асуултуудад хариулъя.

Х.Ганхуяг: 5 номер. С.Магнайрсан дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Би товчхон товчхон хариулахгүй бол цаг бас амждаггүй юм байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв нийцэж байгаа эсэхийг бид ерөнхийд нь үзээд нарийн шалгуураар үзэж дүгнэж чадахгүй байгаа.

Энэ талаар Аюулгүйн зөвлөлийн ажлын албатай яриад хоёр талаасаа ажиллаж байгаа. Тэгээд ойрын хугацаанд бид энэ асуудлыг шийдээд тэгээд С.Эрдэнэболд гишүүнд би энэ талаар мэдээлэл өгье гэж бодож байгаа. Би хэд хэдэн удаа Аюулгүйн зөвлөлийн нарийн бичгийн даргатай ярьсан. Ойрд нэг уулзах хүсэлт тавьсан байгаа. Тэгээд энэ маань шийдэгдвэл нэлээн сууж яриад танд богино хугацаанд шийдээд танд мэдээлэл өгнө.

Аудитын байгууллага хараат бусаар ажиллах ёстой гэдэг дээр олон улсын байгууллагууд манайхыг үнэлж дүгнээд хараат бус нь болж байна. Тэгэхдээ санхүүгийн хувьд нь ийм ийм асуудал байна шүү гээд анхааруулсан байдаг юм билээ. Үүнийгээ бид Сангийн яамтайгаа аль болохоор ойлголцоод яриад явж байгаа.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал дээр хуучин манай аудитын шийдвэр гүйцэтгэх хуудсаар бичигдээд гүйцэтгэгддэг байсан. Одоо бол Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болоод Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хоёр дээр манай зөвхөн татварын байцаагчийн татварын төлбөр тогтоосон акт болоод шүүхийн шийдвэрээр тогтоосон тэр шийдвэрийг л гүйцэтгэнэ гээд гүйцэтгэх хуудас манайд бичигдэхгүй байгаа.

Тэгэхээр бид энэ дээр яг албадлагын журмаар явах юм нь жоохон сул байгаа юм.

Тэгэхээр манайх хуулийнхаа орчин болоод бусад бүх судалгаануудыг хийгээд бэлэн болгосон. Тэгээд үүнийгээ бид энэ чиглэлд нь саналаа оруулж ирээд шийдвэрлүүлээд явбал энэ үр дүнд хүрнэ гэсэн ийм тооцоо хийж байгаа.

Манай байгууллагын тухайд өөрөө Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар гэж тусдаа газартай болсон. 2020 оноос хойших бүх шийдвэрүүдийг бид эмхэтгээд биелсэн, биелээгүйгээр нь ялгаж салгаад, тэгээд одоо ингээд хөөцөлдөж ажиллаж байгаа. Ялангуяа гэмт хэргийн чанартай байж болзошгүй, бас хариуцлага тооцуулахдаа ийм асуудал руу нь бид бас нэлээн анхаарал тавьж орж байгаа.

Энэ тал дээр ингэж хариулах байна.

Засгийн газраас өгсөн төсөв дээр бид өнөөдрийн байдлаар

- Орлого нэмэгдүүлэх нь 51 орчим тэрбум төгрөг.
- Зарлага бууруулах нь 89 орчим тэрбум төгрөг.

Нийтдээ 140 орчим тэрбум төгрөгийн зардлын орон зай байна гэдгийг нэгдүгээрт хэлсэн.

Хоёрдугаарт, төсөвлөлтийн шаардлага хангахгүй байгаа зарим барилга, байгууламжийн энэ онд санхүүжих дүнг нь нийлүүлэх юм бол бараг ингээд 300-аад тэрбум төгрөгийн ийм орон зай байна гэдэг л энэ саналаа бид гаргаж өгсөн байгаа.

Ер нь төсөв дээр зардал бууруулж, орлого нэмэх, ялангуяа халамжтай холбоотой, тэр зорилтот бүлэг чиглүүлэхтэй холбоотой ийм асуудлууд болбол... /минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмэлт 1 минут өгье.

С.Магнайсүрэн: Одоо яг өнөөдрийн байдлаар бид төсөв дээрээ гаргаж тавиад, бүх төсөв захирагч бүрээр нь ингэж ингэж орлого нэмье, ингэж ингэж зардлуудыг нь таная.

Ялангуяа энэ дотор “сургалт”, “хурал”, “зөвлөгөөн”, “семинар”, тэгээд “бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил, үйлчилгээ”. Дээр нь энэ дотор байгаа нэг юу нь “цахимжилттай холбоотой зардлууд”. Тэгээд “гадаад арга хэмжээ”, “уулзалт”, “ёслол” гэсэн ийм чиглэлүүд рүү нь бид голлож анхаарч энэ саналуудыг гаргасан байгаа.

Өнөөдрийн гаргасан бүх саналуудыг бид Байнгын хороон дээр харьяалах чиглэл чиглэлээр нь гаргаж тавиад хэлэлцүүлэхэд бэлэн бэлтгэл хангасан байгаа.

Х.Ганхуяг: Түрүүн С.Эрдэнэболд гишүүний ярьсан, Г.Тэмүүлэн гишүүний ярьсан асуудал дээр дэгийн тухай хуулиар төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр гишүүдэд хүргэж өгч байгаа.

2025 оны хаврын чуулганаар Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг баталсан байгаа.

Үүнтэй холбоотойгоор тайланг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн байна шүү. Шаардлагатай нэмэлтээр хүргүүлэх боломжтой гэсэн үг. Энэ бол хүргүүлсэн байна шүү.

Өөр тодруулж асуух уу? Болсон уу? Болно. С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Сая би уг нь танаас аягүй тодорхой нэг, хоёр, гурав гэж байгаад дараалаад асуусан. Та ерөнхийд нь хариуллаа.

Яагаад гэхээр бид чинь Байнгын хорооны хурал олон нийтэд шууд хүрч байгаа.

Ер нь нээлттэй байх тусмаа, ил тод байх тусмаа, явуулж байгаа ажлаа иргэдэд ойлгуулах тусмаа иргэдийн дэмжлэг болон хяналт чинь илүү хүчтэй болно л гэсэн үг.

Тэгэхээр саяын энэ дотор байгаа, таны саяын дурдаад байгаа, одоо жишээлбэл тэр хууль эрх зүйн гарц. Тийм ээ. Тэр албадлагатай холбоотой асуудал ч гэдэг юм уу, яг үүнийгээ детальчлаад тусдаа тусгайлсан саналууд болгоод хууль санаачлах субъектүүдэд өгөх боломжтой байгаа. С.Магнайсүрэн дарга аа. Үүнийг ингээд детальчилна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр яаж байгаа юм гэхээр энэ чинь цаашлаад олон хууль, эрх зүйн үр дагавар үүсгэсэн зохицуулалтууд байгаа учраас энэ хоорондын чинь уялдааг яаж хангах вэ? Тийм ээ. Захиргааны хууль дээр ч тэр, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр ч тэр. Эд нарыг хоорондынх нь уялдааг яаж хангах вэ гээд.

Тэгэхээр гол нь нэг нь асуусан байдалтай, нөгөөдөх нь хариулсан хариулсан байдалтай юм ингээд дуусмааргүй байгаа юм. Яг энэ чинь цагаан дээр хараар тодорхой зохицуулалт болох юмнууд нь юу байна? Бас дээрээс нь

хэвшүүлэх хэрэгжүүлэх юмнууд нь юу байна гээд бид тодорхой хэмжээгээр алдаагаа засаад, дутагдал юм уу, сул талаа нөхөөд явах тал руугаа л хэдүүлээ хандмаар байгаа юм.

Яах вэ, одоо ингээд Та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Улс орны нөхцөл байдал, улс төрийн ийм эгзэгтэй үе байна. Байнгын хорооны хурал дээр энэ асуудлыг гарын таван хуруу багтах хүн сонсож байна шүү дээ. Тэгээд л цаас нь энэ чигээрээ арван хэдэн хуудастай. Өрөөнд нь туслахынх нь ширээн дээр хуучраад л дуусаа. Тэгээд шийдсэн юм байхгүй болох гээд байгаа байхгүй юу.

Тийм учраас яг одоо энэ дээр бид их тийм өндөр ач холбогдолтой хандмаар байгаа юм. Яагаад гэхээр би Хүний эрхийн дэд хороог, С.Магнайсүрэн дарга аа, Хүний эрхийн дэд хороог даргалж байгаа юм. Тэгэнгүүт яаж байна гэхээрээ бид хүний эрхийн асуудал гэнгүүт одоо ингээд орчны аюулгүй байдал, эрүүл аюулгүй байдал, утааны асуудал гээд цаашлаад шууд хүний эрхтэй холбоцоод байгаа байхгүй юу. Эдийн засаг, өмчийн асуудал ч гэсэн хүний эрхтэй шууд холбогдоод байгаа юм. Тэгэнгүүт яаж байна гэхээрээ Монгол Улс... /минут дуусав/

Х.Ганхуяг: 1 минут нэмээд өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр энэ хаана очоод тулаад байгаа юм бэ гэхээр иргэний эрх чинь очоод нөгөө төсөв, санхүүгийн ил тод байдал, нөгөө талд нь авлига тэр нөхцөл байдал дээр очоод тулчихаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ аудитын газар болбол ерөөсөө энэ идээ бээрийг хурц хутгаар авч байгаа юм шиг энэ алдаануудаа оночилж хараад яаж засах вэ гэдэг юмнуудаа Их Хуралдаа яаралтайгаар илэрхийлээд, Их Хурлын хяналт хэрэгжүүлэх бөгөөд хууль тогтоох боломж, энэ чадавхыг ашиглаад ингээд явах юм бол том боломж байна гэж байгаа юм.

Тэгэхээр тэнд байгаа зовлонгуудаа нөгөө “зовхин доороо нуусан зовлон жаргалаа” өөрөө үүрээд, тэгээд жилд нэг, хоёр удаа аудитын ерөнхий тайлангаа хэлэлцүүлэхдээ хэлдэг бусад үед нь хүмүүс мартдаг нэг ийм зовлон болоод байгаа юм.

Тийм учраас энэ асуулга бол танай байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх, хуулиар олгосон, хуулиар хүлээсэн үүргийг тань илүү үр ашигтай явуулахад чиглэсэн байгаа юм шүү.

Тэгэхээр энэ бол нэг удаагийн зүйл биш, тогтмол үүнийг хэвшил болгож явах ёстой зүйл ээ л гэдгийг би онцолж хэлье. Тэгээд энэ дээр үргэлжлүүлээд хамтарч ажиллая. Баярлалаа.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Монгол Улсын Ерөнхий аудиторт Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн асуудлаар тавьсан асуултын хариуг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул тус хуралдааныг хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 18 минут үргэлжилж, 12 цаг 34 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД